



## **ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

СУРГУУЛИЙН НЭР:                    ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ  
ХӨТӨЛБӨРИЙН НЭР:                БОЛОВСРОЛ СУДЛАЛ /докторын хөтөлбөр/  
ХӨТӨЛБӨРИЙН ИНДЕКС:         F01110101

УЛААНБААТАР ХОТ

2019 ОН

## АГУУЛГА

- А.** Магадлан итгэмжлэлийн үйл явц .....
- Б.** Хөтөлбөрийн товч мэдээлэл.....
- В.** Докторын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлагын дагуу хийсэн шинжээчийн үнэлгээ: ..... **Error! Bookmark not defined.**
1. Хөтөлбөрийн зорилго, агуулга..... 4
  2. Хөтөлбөрийн хэрэгжилт ..... **Error! Bookmark not defined.**
  3. Суралцагчийн үнэлгээ, хөгжил ..... **Error! Bookmark not defined.**
  4. Багшлах бүрэлдэхүүн ..... **Error! Bookmark not defined.**
  5. Нөөц ба удирдлагын мэдээллийн систем**Error! Bookmark not defined.**
  6. Чанарын баталгаажуулалт ..... **Error! Bookmark not defined.**
- Г.** Шинжээчийн багийн дүгнэлт (он.сар.өдөр) . **Error! Bookmark not defined.**
- Д.** Мэргэжлийн зөвлөл Магадлан итгэмжлэх комисс/-ийн шийдвэр (он.сар.өдөр)

## А. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮЙЛ ЯВЦ

<b>Хөтөлбөрийн нэр /монгол хэлээр/</b>	<b>Хөтөлбөрийн нэр /англи хэлээр/</b>
Боловсрол судлал	Educational Studies doctoral program
<p><b>Гэрээ байгуулсан өдөр: 2019 оны 4 сарын 16</b></p> <p><b>ӨҮТ-ийн эцсийн хувилбарыг илгээсэн өдөр: 4 сарын 15</b></p> <p><b>Шинжээч ажиллах /сургууль дээр ажиллах өдөр: 5 сарын 2-3</b></p>	
<p><b>Шинжээчийн баг:</b></p> <p><b>1. Овог нэр: Б.Жадамба</b></p> <p style="padding-left: 40px;"><b>Ажил албан тушаал:</b> МУБИС-ийн Боловсролын суурь судалгааны төвийн эрхлэгч</p> <p style="padding-left: 40px;"><b>Ажлын газар:</b> МУБИС</p> <p><b>2. Овог нэр: Н.Оюунцэцэг</b></p> <p style="padding-left: 40px;"><b>Ажил албан тушаал:</b> Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Хэл соёлын сургуулийн англи хэл, боловсрол судлалын тэнхимийн багш</p> <p style="padding-left: 40px;"><b>Ажлын газар:</b> ХУИС</p>	
<b>БМИҮЗ-ийн мэргэжилтэн: Б.Мядагмаа</b>	
<b>Шийдвэр гаргах мэргэжлийн зөвлөл:</b>	
<p><b>Шалгуур, шаардлага:</b> БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 02 тоот тогтоолоор “ Докторын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”</p>	

## Б. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Хөтөлбөрийн нэр, индекс	Мэргэшлийн салбар	Хөтөлбөрийн багийн ахлагч	Сургалтын хэлбэр	Хугацаа	Кредит
E01110101	Боловсрол судлал	Б.Одгэрэл	Өдөр Эчнээ	3 4	60кр

## **В. ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР, ШААРДЛАГЫН ДАГУУ ХИЙСЭН ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ**

### **ШАЛГУУР 1. ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, АГУУЛГА**

*Докторын хөтөлбөрийн зорилго нь сургуулийн судалгааны бодлого, зорилготой уялдахаас гадна оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.*

#### **Шаардлага 1.1 Хөтөлбөрийн баримт бичиг**

Докторын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагын дагуу хөтөлбөрийн баримт бичгийг иж бүрэн тогтмол сайжруулсан байна. Хөтөлбөрийн баримт бичигт суралцах хугацаанд хийх судалгааны төлөвлөлт, хэрэгжилт, чанарын баталгаажуулалтын талаар тодорхой тусгасан байна.

#### **Баримт нотолгоо:**

- ОТИС нь эрхэм зорилго, алсын хараа, үзэл баримтлалдаа тулгуурлан сургалтын хөтөлбөрүүдийн зорилго, зорилтыг тодорхойлж судалгаанд суурилсан, сургалтын агуулга, чанарын баталгаажуулалт, үндэсний дээд боловсролын салбарын эрхзүйн болон чанарын шалгуур шаардлага болон олон улсын чиг хандлагад нийцүүлэн БСШУСЯ-ны сайдын 2014 оны А\370 дугаар тушаал “Магистр докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ын дагуу хөтөлбөрийг боловсруулсан байна.
- Хичээл тус бүрийн сургалтын хөтөлбөр, мэргэжлийн бэлтгэл хөтөлбөр, Докторантын гарын авлага 2019 он, ОТИС-ийн стратеги төлөвлөгөө /2013-2022 он, 2017-2022 он хүртэлх ОТИС-ийн ЭШСА-ыг хөгжүүлэх хөтөлбөр /Эрдмийн зөвлөлийн 2018 оны 04 сарын 30-ны өдөр/ зэрэг бодлогын болон хэрэгжүүлэлтийг хангах баримт бичгийг батлан, мөрдөн ажилладаг.
- Хөтөлбөрийг 2014, 2017, 2018 онуудад сайжруулсан бөгөөд 2017 оноос судалгааны ажлын явц, удирдагч багштай хамтран ажиллах асуудлыг хянах, төлөвлөх үндсэн аргачлалыг гаргаж, 2018-2019 оны хичээлийн жилээс мөрдөж эхэлсэн байна.
- Мөн хөтөлбөрт чанарын дотоод баталгаажуулалтыг хийх талаар /ОТИС-ийн докторын сургалт зохион байгуулахад баримтлах журмын 3.6.1-д зааж өгсөн байгаа ба хөтөлбөрийн бүтэц дотор тусган оруулсан байна.

#### **Шинжээчийн үнэлгээ: *Бүрэн хангасан***

#### **Дүгнэлт:**

Тус сургууль нь Докторын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагын дагуу хөтөлбөрийн баримт бичгийг иж бүрэн тогтмол сайжруулсан байгаа нь дараах зүйлсээр нотлогдож байна.

- Хөтөлбөрийн баримт бичигт докторын хөтөлбөрөөр суралцагчийн судалгааны ажлын төлөвлөлт болон чанарын баталгаажилтыг хангах

төлөвлөгөөг тусгаж өгсөн. 2017 оноос судалгааны ажлын явц, удирдагч багштай хамтран ажиллах асуудлыг хянах, төлөвлөх үндсэн аргачлалыг гаргаж, 2018-2019 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн.

- 2014 онд хөтөлбөрийн шинэчлэлийг холбогдох бодлогын баримт бичгийн өөрчлөлт, нийгмийн эрэлт хэрэгцээ, сургуулийн эрдэм шинжилгээ судалгааны бодлого төлөвлөлттэй уялдуулан хийсэн ба 2017 онд хөтөлбөрт орсон өөрчлөлт нь ажил олгогч болон суралцагчдын санал хүсэлт зэргийг харгалзан бусад тэнхим, сургууль эрдэм шинжилгээний байгууллагаас сонгон судлах хичээлийн агуулгыг мэргэшүүлэх хичээлийн хүрээнд ангилан оруулж 6 багц цагийг хуваарилан хөтөлбөрт тусгасан ба 2018 онд мэргэжлийн хичээлүүдээс гадна сонгон суралцах чиглэлийн хичээлийн тоог нэмэгдүүлэн агуулгын шинэчлэлийг хийсэн байна.
- Суралцах хугацаандаа докторантууд судалгааны ажлын ганцаарчилсан төлөвлөгөөг гаргаж, батлуулдаг ба судалгааны ажлын хэрэгжилтийг төлөвлөлтийн дагуу хянаж, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлдэг.

### **Шаардлага 1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн төгсгөлд докторантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь тухайн мэргэжлийн чиглэл, боловсролын түвшний үндэсний болон олон улсын нийтлэг чадамжийн хүрээнд дүйцэхүйц байхын зэрэгцээ сургуулийн судалгааны бодлого, зорилгод нийцсэн (өөрийн онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

### **Баримт нотолгоо:**

Хөтөлбөрийн зорилгыг суралцахуйн зорилтот үр дүнгээр тодорхойлсон ба зорилго нь сургуулийн судалгааны бодлого, зорилгод нийцсэн байдал нь дараах зүйлсээр нотлогдож байна.

- Хөтөлбөрийн зорилго сургуулийн эрхэм зорилготой уялдсан нь ОТИС-ийн стратеги төлөвлөгөө /2013-2022 он/ зорилт 1, 2 заасан зорилттой нийцэж байгаагаар илэрхийлэгдэж, өөрийн сургуулийн онцлогийг харуулсан байна гэж үзэж байна.
- ОТИС-ийн ЭШСА-ыг хөгжүүлэх хөтөлбөр 2017-2022 он баримт бичигт тодорхойлсон эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх, судалгааны бодлоготой уялдуулан хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон байна.

Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний хэрэгцээ, шаардлагыг тусгасан байгаа нь:

- Хөтөлбөрийн хорооны журам /ОТИС-ийн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2017, 2019/-д оролцогч талуудын төлөөллийг тодорхой заасан байна.
- Мөн докторантуудаас судалгаа авч тэднээс ирүүлсэн санал, хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх зөвлөмжийн дагуу мэргэжлийн тэнхим хөтөлбөрийн дэд хороотой хамтран сайжруулалтыг хийж ажилладаг нь судалгааны тайлангаар нотлогдож байна. /2015, 2016, 2017, 2018, 2019 оны тайлангууд байв/

- Боловсрол судлалын хөтөлбөрийн онцлогийг харгалзан тус хөтөлбөрөөр төгсөгчийн хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд суурилан хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилгоо хангахаар хөтөлбөрт мэргэжлийн бэлтгэл хичээлийн төлөвлөгөөнд эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр ажиллах, диссертаци бичих, багц цагийг хэрхэн тооцох, судалгааны ажлын арга зүй бүтэц гэх мэт зүйлсийг оруулсан байна.
- Төгсөгчийн загварыг хөтөлбөрийн дэд хороо сургуулийн эрхэм зорилго, эрдэм шинжилгээ судалгааны бодлого, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл зэрэгтэй уялдуулан нийгмийн эрэлт хэрэгцээнд суурилан боловсруулж баталсан, энэ загварт тулгуурлан хөтөлбөрийн зорилго, зорилтыг шинэчилсэн нь өнгөрсөн 5 жилийн гол өөрчлөлт болсон байна.
- Хөтөлбөрийг Орхон ИС, МУИС, МУБИС гэсэн 3 сургуулийн докторын хөтөлбөртэй харьцуулалт хийсэн байна.

### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

- Өөрийн гэсэн төгсөгчдийн загварт түшиглэн зорилго тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилго сургуулийн эрхэм зорилготой уялдсан.
- Хөтөлбөрийг гаднын улс орны ижил төстэй сургалт явуулдаг сургуулиудын хөтөлбөртэй харьцуулсан байдал дутмаг.

### **Шаардлага 1.3 Хөтөлбөрийн агуулга**

Докторын хөтөлбөрийн агуулга нь шинжлэх ухааны чиглэл, суралцахуйн зорилтот үр дүнд нийцсэн байна. Хөтөлбөрийн агуулгыг онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоосон байна.

#### **Баримт нотолгоо:**

- Боловсруулсан хөтөлбөрт багтсан сургалтын төлөвлөгөөнд ямар хичээлийг заавал судлах болон сонгон судлах, онолын болоод практикийн, заавал болоод сонгон судлах хичээлийн харьцааг тодорхой заасан.
- Боловсрол судлалын докторын сургалтад байвал зохих мэргэшүүлэх хичээлүүд багтаасан.
- Хөтөлбөрийн зорилгодоо нийцүүлэн 2017-2018 оны хичээлийн жилээс Боловсролын эрх зүй, Боловсролын менежмент, Боловсролын чанарын судалгааны арга зүй, Оюуны өмч, Олон улсын боловсролын харьцуулалт хичээлүүдийг тус бүрд нь 3 кредитээр хөтөлбөрт нэмж, шинэчилж хичээл хоорондын залгамж, системчлэл, хөтөлбөр дэх судлагдахуунуудыг ерөнхий суурь болон мэргэжлийн чиглэлээр ангилж заавал судлах хичээл болгон тусгасны зэрэгцээ сонгон суралцах хичээлийн тоог нэмэгдүүлж, мэргэшүүлэх чиглэлээр сонгох хичээлүүдийг төрөлжүүлэн оруулсан байна.
- Хөтөлбөрийг нөгөө талаас судлаачид бэлтгэх чиглэлтэй гэдэг үүднээс судлах хичээлийн стандарт төлөвлөгөөнд “эрдэм шинжилгээний ажлын тоон ба чанарын судалгааны арга зүй”, судалгааны ажил, диссертаци, боловсрол судлалын онол арга зүйн судалгаа гэх мэт хичээлүүд тусгагдсан.

- Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн мэргэжлийн суурь хичээлд шинжлэх ухааны нэр томъёо судлах, боловсрол судлалын агуулга, арга зүйг судалгааны түвшинд авч үзэх арга барил бүхий хичээлүүдийг хөтөлбөрийн агуулгад тусган оруулсан.
- Мэргэжлийн суурь хичээлүүдэд тулгуурлан судалгааны ажлыг сурах эзэмших үйлүүдтэй харилцах арга барил, сэтгэл судлалын боловсролд тулгуурлаж сурах, эзэмших үйлийн арга барилыг эзэмшүүлэхэд зохицсон тухайн судлаачийг хөгжүүлэх, төлөвшүүлэх чиг хандлага бүхий мэргэшүүлэх хичээлийг судлахаар оруулсан нь судалгааны ажлын гол бүтэц, судалгааны объект, судлах зүйл, таамаглалын шүтэлцээнд судалж, судалгааны ажлаа бичих чадвар олгож байгаа өөрийн сургуулийн онцлогийг харуулж байна.
- Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн агуулгад багтаж буй хичээл тус бүр нь суралцахуйн зорилтот үр дүнд нийцэж, хувь нэмэр оруулж байгаа байдлыг тодорхойлон хичээлийн залгамж холбоо, ур чадварын матриц гаргасан.
- Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүд суралцахуйн зорилтот үр дүнтэй уялдсаныг матрицаар тодорхойлсон.

### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

- МУБИС-ийн боловсрол судлалын докторын сургалтын төлөвлөгөө ба өөрийн сургуулийн боловсрол судлалын магистрын сургалтын төлөвлөгөөтэй харьцуулсан байна.
- Мэдээллийн олдоц муу, ил тод бус байдлаас хамааран МУ-д боловсрол судлалын докторын сургалт эрхэлдэг бусад их сургуулиудын сургалтын төлөвлөгөөтэй харьцуулалт хийгдээгүй байна.
- 2017 оноос сонгох агуулгатай болсон.

### **Шаардлага 1.4 Хичээлийн хөтөлбөрүүд**

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, докторантын суралцах ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Эдгээрийг байнга сайжруулахын зэрэгцээ тухай бүр суралцагчдад ил тод мэдээлдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Боловсрол судлалын докторын хөтөлбөрийг дэд хороо, мэргэжлийн багш нар хөтөлбөрийг боловсруулан, хөтөлбөрийн дэд хороо хянан сайжруулах, баталгаажуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцыг үнэлэх, бусад ижил төст хөтөлбөрөөр үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын хөтөлбөртэй харьцуулан хөтөлбөрийн чанарын шинэчлэл хийдэг.
- Хөтөлбөр боловсруулах үйл явцын зураглал, үйл ажиллагааны зохион байгуулалт нь хөтөлбөрийн хороодын ажлын уялдааг хангах, үр дүнг сайжруулахад эерэг нөлөө үзүүлж байна.

- Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн үзэл баримтлал нь суралцагчдын эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн, олон улсын хөтөлбөрийн стандартыг хангасан, хөдөлмөрийн зах зээлд ажиллах гадаад хэлний мэдлэг, мэргэжлийн ур чадвараас гадна нийгмийн харилцаанд үүрэг хариуцлагаа ухамсарлах төлөвшлийг олгоход чиглэгдсэн төгсөгчийн мэргэжлийн болон мэргэжилтний ёс зүйн шаардлагыг хангаж байна.
- Сургалтын хөтөлбөрүүд нь дотоодын магадлан итгэмжлэлийн болон олон улсын стандартад нийцүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж байгаа байдал нь тус сургуулийн давуу тал болохыг дурдах нь зүйтэй.
- Хөтөлбөрийн үнэлгээг мэргэжлийн багш нар тэнхим, нэгжийн хүрээнд хэлэлцүүлгээр зохион байгуулж, үр дүнд нь санал, асуудал дэвшүүлэн хөтөлбөрийн дэд хороонд хүргүүлдэг тогтолцоотой байгаа нь хамтын удирдлагаар чанарын үнэлгээг хийж байгааг харуулж байна.
- Боловсрол судлалын мэргэжлийн бус суралцагчдад зориулсан 15 кр багтаамжтай, мэргэжлийн хичээлүүдээс багтсан мэргэжлийн бэлтгэл хөтөлбөрийг боловсруулсан байна.
- Докторын сургалтын төлөвлөгөөнд багтсан хичээлүүдийг доктор, түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой багш нар заах бөгөөд хичээл тус бүрийн хөтөлбөрийг нийтлэг шаардлагын дагуу боловсруулж сургуулийн захирлаар батлуулан мөрддөг. Хичээлийн хөтөлбөрт хичээлийн зорилго, уялдаа холбоо, үнэлгээний аргачлал, тухайн хичээлийн багц цаг зэргийг багтаасан байгаа бөгөөд докторантуудад гарын авлага, удирдлагын мэдээллийн системээр мэдээлдэг байна.

#### **Зөвлөмж:**

- Захиргаа хяналт, шинжилгээ, үнэлгээний албанаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үнэлгээний давтамжийг нэмэгдүүлэх, бүх хөтөлбөрийг хамруулах
- Хичээлийн хөтөлбөрийн сайжруулалтыг хийхдээ оролцогч талуудыг хэрэгцээ шаардлагын судалж, түүнд үндэслэн боловсруулах
- Сургалт зохион байгуулах хэлбэрт хэлэлцүүлэг, мэтгэлцээн, холимог сургалтын хэлбэрүүдийг ашиглах

**Шинжээчийн үнэлгээ:** Хөтөлбөр зохих шаардлагыг ханган боловсруулагдсан бөгөөд хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг докторантуудад удирдлагын мэдээллийн систем болон иж бүрэн гарын авлагаар дамжуулан хүргэдэг тул тус шалгуурыг **бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

#### **Дүгнэлт:**

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан бөгөөд хөтөлбөрийн талаарх мэдээлэл нь удирдлагын мэдээллийн системдээ бүрэн орсон, докторантууд өөрийн кодоороо нэвтэрч хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хичээл заах багшийн талаарх мэдээллийг авах нөхцөл бүрдсэн байна.

Хөтөлбөр боловсруулах тогтсон үйл явцтай бөгөөд хөтөлбөрийг боловсруулах

үйл явцаас нь эхэлж хянаж ажилладаг байна.

#### **Шаардлага 1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага**

Докторын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байна.



## **Баримт нотолгоо:**

- Энэхүү шалгуур нь БМИҮЗ-өөс хамааралтай бөгөөд Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлага докторын хөтөлбөрт боловсруулагдаагүй байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Докторын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь мэргэжилтний загвараа ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр тодорхой гаргасан тул тус **шалгуурыг бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

## **Дүгнэлт:**

Боловсрол судлалын докторын хөтөлбөрөөр төгсөгчийн загвар: эрхэмлэх зүйл, суурь чадамж, академик болон прагматик чадамж гэсэн үндсэн 3 чиглэлээр Эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухааны мэдлэг, судлаачийн нийгэмшихүйн чадамж, академик мэдлэг, судлаачийн хувь хүний чадамж, прагматик мэдлэг чадвар гэсэн байдлаар боловсрогдон түүндээ эзэмших ур чадварыг нарийвчлан тусгасан байна.

Докторын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь мэргэжилтний загвараа ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр тодорхой гаргасан тул тус **шалгуурыг бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

## **Шалгуур 1. Шинжээчийн үнэлгээ:**

- Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга нь сургуулийн судалгааны бодлого, зорилготой уялдахаас гадна оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусгасан байдал нь тогтоосон шаардлагад бүрэн нийцсэн.
- Холбогдох дүрэм журам, шаардлагыг үндэслэн сургалтын хөтөлбөрүүдийн шинэчлэлийг хийдэг. /А370/
- Хөтөлбөрийн хороо нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлийн харьцаа, хичээл хоорондын уялдаа холбоог хангасан.
- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хөтөлбөрийн дэд хороо хянаж, сайжруулах шаардлагатай ажлуудыг хийдэг.
- Өөрийн сургуулийн хөтөлбөрийн онцлог, хөтөлбөрт оролцогч талуудын хэрэгцээг судалсны үндсэн дээр мэргэжилтний загвараа гаргасан нь мэдлэг, чадвар, хандлагын төлөвшилт нь үндэсний болон олон улсын стандартад нийцсэн гэж үзэж байна.
- ОТИС-ийн эрхэм зорилго нь “Мэдлэгээрээ баялаг бүтээж, манлайлах чадвартай, ёс суртахуунтай мэргэжилтэн бэлтгэнэ” гэж тодорхойлсон байгаа ба хөтөлбөрийн зорилго нь “Хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн хөтөлбөрөөр мэргэжлийн өндөр мэдлэгтэй, бүтээлч сэтгэлгээтэй, хариуцлагатай, өөрийгөө хөгжүүлэх чадвартай, хөрвөх чадвартай, мэдлэгээрээ баялаг бүтээх чадамжтай, өөрчлөлтөд бэлэн байх, зөв хандлагатай мэргэжилтнийг бэлтгэх”-д чиглэгдэж байгаа нь сургуулийн эрхэм зорилготой нийцэж байгааг харуулж байна.
- 2018-2019 оны хичээлийн жилд хичээл удирдагч багш нарыг үнэлүүлдэг болсон. /тайлантай/

## **Шалгуур 1. Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг бүрэн хангасан**

Тус сургууль нь докторын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шаардлага 1-д заагдсан шалгуурын дагуу боловсрол судлалын докторын хөтөлбөрийн зорилго нь сургуулийн эрдэм шинжилгээ судалгааны тэргүүлэх чиглэл, судалгааны

бодлого, сургуулийн эрхэм зорилготой уялдсан, хөтөлбөрт оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусган хэрэгжүүлж байгаа нь нотлох баримтаар нотлогдож байгаа тул тус **шаардлагыг бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

- Салбарын тэргүүлэх эрдэмтэн мэргэжилтэн, доктор, профессорууд хичээл заадаг
- Сонгон суралцах, мэргэшүүлэх хичээлийн агуулгыг хөтөлбөрт илүү тусгасан
- Төгсөгчдийн загварыг боловсруулан суралцахуйн зорилтот үр дүнгээ тодорхойлсон
- Эрдэм шинжилгээ, судалгааны төв, Нийгмийн судалгааны төвд зөвлөх профессорын багтай хамтран ажиллуулдаг.
- Холбогдох дүрэм журам, эрх зүйн орчин бүрдсэн
- Хөтөлбөрийн шинэчлэлд хөтөлбөрт оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон тусгаж, сайжруулдаг.
- ОТИС-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийн хүрээнд докторантуудын судалгаа хийлгэх, хамтарч ном, бүтээл туурвих боломжтой.
- Докторантурт суралцагчид хамгаалах байдал нь удаашралтай.

### **Шалгуур 1. Зөвлөмж:**

- Хамгаалуулах зөвлөлтэй албан ёсоор хамтран ажиллах /гэрээ байгуулах, хамтран ажиллах санамж бичиг байгуулах г.м/
- Хөтөлбөрийн зорилт, үр дүнгийн хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, байнгын сайжруулалт хийх тогтолцоог төгөлдөржүүлэх,
- Хөтөлбөрт тавигдах тусгай шаардлагыг тодорхой болгох талаар БМИҮЗ-тэй хамтран ажиллах
- Хөтөлбөрийн зорилгоо хангах зорилтуудыг дэвшүүлэн тавьж түүнийг хэрэгжүүлэх арга зүйг тодорхой болгох
- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг боловсруулахдаа оролцогч талуудын оролцоо, тэдний хэрэгцээ шаардлагыг тусган хэрэгжүүлэх үйл явцыг нарийвчлах,
- Өөрийн болон гаднын улс орнуудын ижил төстэй сургалтын хөтөлбөрүүдтэй харьцуулан боловсруулалт хийж өөрийн хөтөлбөрийн давуу талыг тодорхойлох
- Захиргаа хяналт, шинжилгээ, үнэлгээний албанаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үнэлгээний давтамжийг нэмэгдүүлэх, бүх хөтөлбөрийг хамруулах
- Боловсрол судлалын магистрын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх

### **ШАЛГУУР 2. ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

***Докторын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчныг бүрдүүлж, докторантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.***

#### **Шаардлага 2.1 Элсэлт**

Элсэгчид тавих шаардлага нь докторын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг олгосон, шударга, ил тод байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

## **Баримт нотолгоо:**

- Элсэлтийн бодлого төлөвлөлттэй. Элсэлтийн үйл ажиллагаанд ОТИС-ийн докторын сургалт эрхлэхэд баримтлах журмыг мөрдөн ажиллах ба тус журмын 3.7-д элсэгчдэд тавих шаардлага, судалгааны сэдэв сонгох, удирдагч багшаа сонгох, сургалтын хэлбэр, сургалтын төлбөр гэх мэт мэдээллүүдийг нарийвчлан тусган оруулсан байна.
- Докторын хөтөлбөрийн элсэгч нь тухайн мэргэжлийн чиглэлээр элсэлтийн шалгалт өгнө. Мэргэжлийн шалгалт бичгийн болон ярилцлагын гэсэн 2 үе шаттай. Бичгийн шалгалтаар тухайн элсэгчийн судалгааны сэдвийн үндэслэл, ач холбогдлыг илэрхийлсэн эсээ бичүүлэн шалгуулагчийн сонгосон судалгааны сэдвийн чиглэлийн профессортой сэдвийн тулгамдсан байдлыг хэлэлцэж шалгаруулалтыг хийдэг ба энэ талаарх шалгуулагчдын материалыг нотлох баримтаар оруулсан байна.
- Өөр мэргэжлийн чиглэлтэй зохих шаардлага хангасан магистр боловсрол судлалын докторын бэлтгэл хөтөлбөрөөр нэмэлт багц цаг судлан мэргэжлийн шалгалт өгснөөр “Боловсрол судлал” докторын хөтөлбөрт элсэн суралцаж болно.
- Магистрант, докторант шилжүүлэн суралцуулах журам, багц цаг дүйцүүлэн тооцоход баримтлах журамтай, шилжүүлэн суралцуулах журмын 3.2-д шилжин ирж байгаа их сургууль нь магадлан итгэмжлэлд орсон байхыг заасан байна. /ОТИС-ийн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл х.155/
- Элсэлтийн мэдээллийг сургуулийн албан сайт болон өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарладаг ба элсэлтийн үйл ажиллагааг томилогдсон комисс тогтсон үйл явцын зураглалын дагуу явуулдаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Шаардлага 2.1-д заагдсаны дагуу элсэгчдэд тавих шаардлага тодорхой байгаа ба мэдээллийг ил тод нээлттэй эх сурвалжаар мэдээлдэг тул тус шаардлагыг **бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

Докторын хөтөлбөрт элсэгчийг томилогдсон элсэлтийн комисс сонгон шалгаруулах ба комиссыг жил бүр ОТИС-ын захирлын тушаалаар шинэчлэн байгуулдаг ба тус комисс нь элсэгчдийг бүртгэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

- Докторын хөтөлбөрийн элсэлтийн шалгалтыг жилд нэг удаа 9 сард зохион байгуулдаг ба 8 сард элсэлт авах тухай болон элсэгчид тавигдах шаардлагын талаарх мэдээллийг өдөр тутмын мэдээллийн хэрэгслүүд болон сургуулийн албан сайтаар дамжуулан мэдээлдэг.
- Элсэлтийн үйл ажиллагааны зураглалтай, түүндээ тулгуурлан бүх үйл явцыг хянаж ажилладаг.
- Элсэлтийн үйл ажиллагааг 2017-2018 оны хичээлийн жилээс цахим хэлбэрт шилжүүлсэн. /otgontenger.gate.mn/
- Элсэлтийн үйл ажиллагааны маркетингийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн ба мэдээллийг шуурхай авах боломж бүрдүүлсэн. /МА ажилладаг
- Докторын судалгааны ажлын сэдэв сонголт болон удирдагч багшийн талаарх мэдээлэл элсэлтийн баримт бичигт дурьдагдаагүй байна.

- Элсэлтийн шаардлагад “судалгааны ажлын арга зүй эзэмшсэн байх”, “англи хэлний мэдлэгтэй байх” гэсэн шаардлагуудыг орууж өгвөл сайн байна.

### **Дүгнэлт:**

Докторын хөтөлбөрийн элсэгчид тавих шаардлага, судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох тухай нарийвчилсан заалтууд, докторын сургалт эрхлэхэд баримтлах журамд тодорхой тусгасан ба ил тод мэдээлдэг болохыг дараах нотлох баримтаар нотолж байна.

- 2017-2018 оны хичээлийн жилээс хөтөлбөрийн танилцуулгын талаар брошюр хийж, хөтөлбөрийн мэдээллийг элсэгчдэд хүргэсэн.
- 2016-2017 оны хичээлийн жилээс элсэлтийн үйл ажиллагааг тогтмол сурталчлан таниулж, мэдээллийг нээлттэй ил тод хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн Маркетингийн алба байгуулан, үйл ажиллагаа тогтмолжсон.

### **Шаардлага 2.2 Суралцах ачаалал, багц цаг**

Докторантын танхимд болон бие даан суралцах, судалгааны ажлын ачаалал нь улирал бүрд жигд, зохистой хэрэгжиж, хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна.

### **Баримт нотолгоо:**

Докторантын танхимд болон бие даан суралцах, судалгааны ажлын ачаалал нь улирал бүрд жигд, зохистой хэрэгжиж, хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг болохыг дараах нотлох баримтаар нотлогдож байна.

- Докторын сургалтын төлөвлөгөө нь 60 багц цаг байна. Эрдэм шинжилгээний ажлын багц цаг 12 багц цагаас багагүй байдаг. Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн судалгааны ажлын багц цаг 6 кр, диссертацийн ажил 24 кр цаг байна.
- Судалгааны ажлын ачаалал нь улирал бүрд жигд, зохистой хэрэгжиж, хэт ихсэх буюу багасахаас сэргийлэн сургалтын нэгдсэн албанаас хичээлийн хуваарь гарган нэгдсэн удирдлагаар ханган хичээлд хамрагддаг ба Докторын сургалт эрхлэхэд баримтлах журмын 3.2.10-д 1 улиралд судлах багц цагийн дээд хязгаарыг тогтоож өгсөн байна.
- Докторын хөтөлбөрийн хувьд улиралд дунджаар 10 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судалбал зохих багц цагийн дээд хэмжээ 15 байна.
- Суралцагчийн суралцах явц болон судалгааны ажлын ачааллыг улирал бүрд жигд, зохистой хэрэгжүүлэх болон хэт ихсэх буюу багасахаас сэргийлэх зорилгоор докторант нэг бүр ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж төлөвлөгөөний дагуу хичээл судалж, удирдагч багшийн

удирдлага дор судалгааны ажлаа гүйцэтгэнэ. Ганцаарчилсан төлөвлөгөөний хэрэгжилт сургалтын нэгдсэн алба хяналт тавьж ажилладаг.

**Шинжээчийн үнэлгээ:** Шалгуур 2.2-д заагдсан суралцах ачаалал, багц цагийн зохистой байдлыг тогтоосон шалгуурыг журмын дагуу **бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

**Дүгнэлт:**

- Суралцах ачаалал, багц цаг журмын дагуу байна.
- Нэг улиралд судлах багц цагийн дээд хязгаарыг тодорхойлж өгсөн.
- Оюутны сургалтын ачааллын талаарх шууд судалгаа байхгүй, түүнчлэн ачаалал хэт ихэдсэн тохиолдолд хэрхэн зохицуулах талаарх механизм байхгүй
- Бусад сургуулиудын профессоруудыг урьж ажиллуулдаг хэдий ч зарим оюутнуудын зүгээс сургалт, судалгааны хүрээг нэмэгдүүлэх зорилгоор олон өөр багш нараар хичээл заалгах хүсэлтэй байгаа талаар илэрхийлж байсан.

### **Шаардлага 2.3 Судалгааны болон суралцах арга зүй**

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, оюутанд хөтөлбөрийн үр дүнд хүрэх боломжийг олгосон байна.

**Баримт нотолгоо:**

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, оюутанд хөтөлбөрийн үр дүнд хүрэх боломжийг олгосон байдлыг дараах нотлох баримтаар нотолж байна.

- Профессор багш нарын баг боловсрол судлалын хөтөлбөрт суралцаж буй докторантуудын судалгааны ажлын явцыг хэлэлцэх “Эрдэм шинжилгээний их семинар”-ыг 2015 оноос эхлэн зохион байгуулж хэвшсэн байна.
- Докторантууд доктор, зөвлөх профессоруудыг дагалдан судалгааны багт ажилладаг.
- 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар нийт 16 докторант 9 профессоруудыг дагалдан судалгааны ажил хийж байна.
- Сургалтын арга зүй нь сонирхол татахуйц, өөрийгөө үнэлэх, мэдрэх боломжтой, бие даан суралцах боломж бүрдүүлсэн SPICES зарчимд тулгуурласан, үр дүнд суурилсан, идэвхтэй сургалтын аргуудаас ашигладаг. Тухайлбал, суралцагч судалгааны ажлын сэдвээр илтгэл бэлдэн хэлэлцүүлэх, хичээлийн агуулгын зарим хэсгийг мэргэжлийн/ удирдагчийн их семинарт илтгэх, хэсэг бүлгээр хувааж бие даалтын ажил бичих, нөхцөлт судалгаа (case study) хийх зэрэг хэлбэрээр багц цагаа тооцуулахыг зөвшөөрдөг байдал нь хөтөлбөрийн зорилтот үр дүнд нийцсэн байгааг харуулж байна.
- 2015 оноос эрдэм шинжилгээний их семинар, судлаачийн цаг, “science café” зэргийг зохион байгуулж эхэлсэн.

**Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Дүгнэлт:**

- Зөвлөх профессоруудыг дагалдуулан ажиллуулдаг.
- Их семинар, судлаачийн цаг, science safe зэргээр судалгааны ажлын явц үр дүнг хэлэлцдэг.
- Суралцагч төвтэй хөтөлбөрийн зорилгод нийцсэн сургалтын шинэлэг арга хэрэглэх боломжийг хөтөлбөрт тодорхой хэмжээнд тусгасан байна.

### **Шаардлага 2.4 Судалгааны ажлыг удирдах**

Докторант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу докторантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна.

## **Баримт нотолгоо:**

- Докторантуудын судалгааны ажлын явц, гүйцэтгэлийг хичээлийн жилд хоёр удаа хэлэлцэн зөвлөгөө өгдөг.
- Судалгааны ажилд тавигдах шаардлага шалгуур, докторант болон удирдагчийн үйл ажиллагааг Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам болон ОТИС-ийн докторын сургалтын журмаар зохицуулдаг.
- ОТИС-ийн зөвлөх профессор болон докторын сургалтад идэвхтэй оролцдог, өөр байгууллагад судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхэлдэг, докторын зэрэгтэй судлаач, багш докторантад хичээл зааж, удирдагчаар ажиллаж болно. Докторантын судалгааны ажлын сэдэв нь шинжлэх ухааны 2-3 салбарт хамаарахаар бол 2 удирдагчтай байж болдог.
- Сургалтын төлөвлөгөөнд нийцүүлэн докторант тус бүр судалгааны ажлыг хийх ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулан удирдагч багшаар батлуулж, төлөвлөгөөний дагуу ажилладаг. Ганцаарчилсан төлөвлөгөөг Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал батална.
- 2015-2016 оны хичээлийн жилээс докторантуудын судалгааны ажлын явц, гүйцэтгэл хэдэн хувьтай байгаад хяналт тавин ажиллаж, тэдний ажлын явцыг хичээлийн жилд 2 удаа хэлэлцэн зөвлөгөө өгч ажиллаж байгаа нь докторантын судалгааны ажлын явцыг хянан гүйцэтгэлийг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой болсон төдийгүй 2016 онд 1 төгсөгч хамгаалсан байна.
- Судалгааны ажлын явц, удирдагч багшийн докторанттай хамтран ажиллах байдлыг үнэлэх товч тайланг докторант, удирдагч багш хичээлийн жилд 1 удаа бичиж ЗХШҮА-д хүргэх ба тус үнэлгээнд үндэслэн багшийг урамшуулах механизмыг бүрдүүлэн ажиллаж байгаа нь давуу талтай байна. Энэ талаар Докторын сургалтын журмын 4.1.7, 4.1.8-д заасан байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

## **Дүгнэлт:**

- Сэдэв сонголт хийдэг тогтсон дэг жаягтай
- Удирдагч багшид тавих шаардлагатай. Хичээлийн жилд удирдах докторантыг судалгааны сэдвийн чиглэлээс хамааруулан тогтоодог байна.
- Журмууд үр дүнтэй хэрэгжиж буй эсэхэд ЗХШҮА хяналт тавин ажилладаг байна.
- Судалгааны ажлын боломжит удирдагчдын тоог нэмэгдүүлэх, дотоод болон гадаадын судлаачдыг татан оролцуулах хэрэгтэй. Түүнчлэн олон улсын судалгааны байгууллагуудаас хамтарсан удирдагчтай ажиллах боломжоор хангах

### **Шаардлага 2.5 Судалгаа, хамтын ажиллагаа**

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, докторантууд судалгааны багт оролцдог байна.

#### **Баримт нотолгоо:**

- Докторантын эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хэлэлцэх, үр дүнг нь сайжруулах зорилгоор жил бүр “Эрдэм шинжилгээний их семинар” зохион байгуулж удирдамж, төлөвлөгөөг батлан хичээлийн жилийн эхэнд нийтэд танилцуулдаг.
- Докторын хөтөлбөрөөр суралцагчдын суралцахуйн үр дүнг дээшлүүлэх, судалгаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, судалгааны үр дүнг чанаржуулах зорилгоор Олон улсын 12, төрийн байгууллага 15, мэргэжлийн байгууллага 9, бизнесийн 8 байгууллагатай идэвхтэй хамтын ажиллагаатай гэрээтэй.
- Захиалгат болон өөрийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдээс гадна бусад байгууллагатай хамтран судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсөл хөтөлбөр хэрэгжүүлж сүүлийн 5 жилд Олон улсын 2, үндэсний хэмжээний төсөл 5, дотоодын санхүүжилтээр 4, захиалгат төсөл 2-ыг тус тус хэрэгжүүлсэн.
- Боловсрол судлалын докторын хөтөлбөрт суралцагч докторантыг Тогтвортой хөгжлийн боловсрол, Эрасмус плас С3QA төсөлд гишүүнээр ажиллуулсан байна. /төслийн тайлан, мэдээлэлд докторантын мэдээлэл тусгагдсантай танилцав/

**Шинжээчийн үнэлгээ:** Шаардлага 2.5-д заагдсан судалгаа, хамтын ажиллагааны шалгуурт заасны дагуу идэвхтэй хамтын ажиллагаатай байгууллагуудын гэрээтэй ба хамтын ажиллагааг дүгнэдэг, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт докторантуудыг хамруулдаг байна. Тус шалгуурыг **бүрэн хангасан** гэж дүгнэж байна.



## **Дүгнэлт:**

Дотоодын болон гаднын санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөлд докторантуудыг дагалдуулан ажилладаг. Тухайлбал: “Оюуны өмч” гарын авлага-2015, “Тогтвортой хөгжил” гарын авлага-2017, Багш, докторантуудад зориулсан англи хэлний эрчимжүүлсэн сургалтын төсөл-2018, Эрасмус Арров төсөлд хамруулан судалгааны дата ашиглах сургалтад 5 докторантыг хамруулсан байна.

- Үндэсний хэмжээний судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах хүрээг нэмэгдүүлж, цаашид олон улсын судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй байна.
- Олон улсын судалгааны байгууллагуудаас судалгааны санхүүжилт авах талаар санаачилга гарган ажиллах шаардлагатай.
- Хамтарсан судалгааны ажлыг илүү эрчимжүүлэх хэрэгтэй.

### **Шаардлага 2.6 Диссертаци хамгаалах**

Диссертаци хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь докторант, удирдагч нарт ойлгомжтой байна.

Диссертаци хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) –ийг докторант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар тодорхойлогдсон байна.

## **Баримт нотолгоо:**

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд ОТИС-ийн судалгааны ажлын стандарт /CS110413:2018/, оюуны өмчийн гарын авлагыг мөрдөн ажиллаж байна.
- Олон улсын АРА академик бичлэгийн загварт суурилсан. 2018 оны 04 сарын 28 өдрийн хурлаар хэлэлцэж баталсан, ОТИС-ийн сургалт, судалгааны стандарт нь CS11-0413:2018 тоот стандартын дугаартай.
- Хамгаалалтын үйл явцын тогтсон зураглалтай.
- Боловсрол судлалын докторын хөтөлбөрөөр тайлант хугацаанд 2 докторант хамгаалсан.
- Докторын ажлыг тогтоосон журмын дагуу бүрэн эхээрээ үдэгдсэн байдлаар сургуулийн архивд хадгалах ба 2%-ийг номын санд хүлээлгэн өгнө. ОТИС-ийн ЭШСТ нь докторын диссертациар мэдээллийн электрон сан үүсгэж, жил бүр баяжуулж хадгална.
- Хамгаалуулах үйл явц нь Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм<sup>1</sup> болон МУБИС-ийн Докторын ажил хамгаалуулах зөвлөлийн дүрмийг удирдлага болгодог.
- Хамгаалалтад орох докторант Докторын сургалтын журмын 4.2.2-д заасан материалыг бүрдүүлэн докторын зэрэг хамгаалах зөвлөлд илгээдэг.

## **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

---

<sup>1</sup>БСШУ-ны сайдын 2010 оны 11 сарын 4-ны өдрийн 492 дугаар тушаалын хавсралт



## **Дүгнэлт:**

- Албан ёсны стандартын дугаартай олон улсын АРА академик бичлэгийн загварт суурилсан стандарттай.
- Хамгаалалтын үйл ажиллагаа үндэсний хэмжээний хамгаалуулах зөвлөлд явагддаг тул хамгаалалтыг зохион байгуулах ажил тус сургуулиас хамааралтай бус байдаг.
- Санал, гомдол гарсан бол энэ талаар ямар арга хэмжээ авсан тодорхойгүй
- Холбогдох дүрэм, журам, шалгуурууд нь шударга, ил тод хэрэгжиж байгааг хэрхэн үнэлж, баталгаажуулдаг байдал тодорхой байна.
- Докторантуудын сэтгэл ханамжийн судалгаа авдаг.
- Диссертаци хамгаалалтыг зохион байгуулах дүрэмтэй.
- Хамгаалуулах үндэсний зөвлөлтэй яаж хамтран ажилладаг байдал тодорхойгүй.
- Урьдчилсан хэлэлцүүлэг болон урьдчилсан хамгаалалтыг тухайн чиглэлийн профессоруудыг өргөн хамруулж, боломжтой бол нээлттэй байдлаар зохион байгуулах шаардлагатай.

### **Шаардлага 2.7 Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшнийг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

### **Баримт нотолгоо:**

- Танхимын багц цагийг бүрэн гүйцэтгэсэн докторантад англи, монгол хэлээр боловсрол судлалын докторын хөтөлбөрөөр сургалтын багц цагийг дүүргэсэн болохыг нотолж гэрчилгээ олгоно
- Докторын диплом нь хавсралттай байх ба хавсралтад тухайн төгсөгчийн суралцах хугацаанд судалсан хичээлүүд, тэдгээрийн кредит, голч дүн, оноог бичиж, хавсралтыг ОТИС-ийн захирал, Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, бүтцийн сургуулийн захирлын гарын үсэг, ОТИС-ийн тэмдгээр баталгаажуулна.
- Диплом, хавсралтын загвар нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан загварт нийцсэн.
- Төгсөлтийн бичиг баримт олгох үйл явц зураглалын дагуу явагдаж хянадаг.
- Докторын ажлаа амжилттай хамгаалсан төгсөгчид докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ОТИС-ийн захирлын

тушаалаар Докторын зэрэг олгох шийдвэр гаргаж, тус шийдвэрийг үндэслэн СНА дипломыг бичиж, гардуулах ажлыг зохион байгуулдаг.

### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

- Төгсгөлтийн баримт бичиг олгох үйл явц тодорхой
- Тухайн төгсөгчийн чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолтын мэдээллийг оруулдаггүй байна.

#### **Шалгуур 2. Шинжээчийн үнэлгээ:**

- Элсэгчид тавих шаардлага нь хууль тогтоомжид нийцсэн, ил тод, шударга. Элсэгчдэд зориулсан маркетингийн бодлого хэрэгжүүлдэг.
- Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох журам нь БСШУЯ-ны нийтлэг журамд нийцсэн
- Бусад мэргэжлийн магистр тус хөтөлбөрт элсэн суралцах боломжийг хангасан бэлтгэл хөтөлбөртэй.
- Судалгаа, инновацын хөгжлийн стратегитай
- Судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон
- ОТИС-ын сургалт, эрдэм шинжилгээний ажлын бичилтийн албан ёсны дугаартай стандарттай.
- БСШУЯ-ны журамтай уялдуулан Докторын сургалт явуулах журмыг цаг тухайд нь шинэчлэлийг тусган мөрдөж ажилладаг байдал нь эрх зүйн орчин бүрдсэн байгааг харуулж байна.
- Докторын сургалт хариуцсан нэгж нь сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлын удирдлага дор ажилладаг ба удирдлага зохион байгуулалтын талаар Докторын сургалтын журмын 2-р бүлэгт тодорхой заасан байдаг нь докторын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, бүрдсэнийг харуулж байна.
- Боловсрол судлалын хөтөлбөрийг хариуцсан мэргэжлийн тэнхим ажиллаж байгаа байдал нь докторантын суралцахуйн үйл явцыг дэмждэг болохыг харуулж байна.
- Судалгаа эрдэм шинжилгээний ажлын явцыг дэмжих зорилгоор Эрдэм шинжилгээний төвийг ажиллуулдаг.
- Судалгааны тэргүүлэх чиглэлтэй. Түүндээ тулгуурлан докторын эрдэм шинжилгээний хурлаа зохион байгуулах, докторантууддаа сэдэв сонгуулах ажлуудыг хийдэг.

#### **Шалгуур 2. Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг бүрэн хангасан**

#### **Шалгуур 2. Зөвлөмж:**

- Хамгаалах зөвлөлтэй хэрхэн хамтарч ажиллах, хамгаалах үйл явцыг нэмэгдүүлэх талаар тодорхой ажлыг төлөвлөн ажиллах
- Боловсрол судлалын судалгааны сэдвийг орчин үеийн тулгамдсан асуудалд төвлөрүүлэх
- Гадаадын их сургуулиудтай хамтарсан судалгааны ажлыг эрчимжүүлэх
- Удирдагч багш нарыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй ажлуудын үр дүнг үндэсний хэмжээнд болон оюутан суралцагчдад чиглэсэн гэсэн хэлбэрээр

төрөлжүүлэн үр дүнг дүгнэдэг, цаашдын үйл ажиллагааны төлөвлөлтөнд хэрэглэдэг байх

- Оюутны гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх үйл явцыг тодорхой болгох

### **ШАЛГУУР 3. ДОКТОРАНТЫН ҮНЭЛГЭЭ, ХӨГЖИЛ**

***Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.***

#### **Шаардлага 3.1 Суралцагчийн үнэлгээ, шалгалт**

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь оюутны сурлагын амжилтыг шударга ил тод үнэлэхэд чиглэсэн байна. Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг цогцоор үнэлэх шалгалтын материалын санг хичээл бүрээр боловсруулж, ашигладаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Хичээлийн хөтөлбөрт үнэлгээний зорилго, үнэлгээний хэлбэр, шалгуур үзүүлэлт, сэдвийн жишиг үнэлгээ, бие даалтын ажлын сэдэв, түүний хугацаа, үнэлэх хэлбэрийг тусгасан.
- Судалгааны ажлыг эрчимжүүлж, чанартай болгох үүднээс эрдмийн зөвлөлийн гишүүд, зөвлөх профессор багш нараас бүрдсэн хурлыг зохион байгуулж, докторантын судалгааны ажлын явц, үр дүн, бүтэц, онол, арга зүйг нээлттэй хэлэлцэн, үнэлгээ, дүгнэлт, зөвлөгөө өгч ажилладаг.
- Докторын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг тооцох комиссыг тэнхимийн эрхлэгч, удирдагчийн саналыг үндэслэн ОТИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж, “багц цаг дүйцүүлэн тооцуулах журам”-ыг баримтлан тооцож, сургалтын мэдээллийн системд оруулдаг.
- Хичээлээр эзэмшсэн суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ мэдлэг, чадвар, дадлыг цогцоор үнэлж, ашигладаг.
- Ямар түвшинд үнэлгээ хийж байгаагаас хамаарч шууд ба шууд бус үнэлгээний төрлийг ашигладаг. Шууд үнэлгээг шалгалтын материалын санг хичээл бүрээр боловсруулж авдаг. Шууд бус үнэлгээг дадал, чадвар, хандлагыг үнэлэх рубрик үнэлгээний аргыг ашигладаг байна.
- Докторант нь мэргэжлийн хичээлийн багц цагийг амжилттай судалсны дараа докторын судалгааны ажлыг эхлүүлэхийн өмнө нэгдсэн шалгалт өгнө. Мэргэжлийн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хичээл тус бүрээр хөтөлбөрийн хороо тодорхойлон хэрэгжүүлдэг.

#### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

- Доктрантуудыг суралцахуйн үр дүнг (мэдлэг, чадвар, хандлага) системтэйгээр, олон янзын арга, хандлага ашиглан үнэлдэг байх шаардлагатай.
- Бакалавр, магистрын үнэлгээнээс ялгагдах тал бага байна.
- Докторантын судалгааны ажлын чанарыг үнэлэх асуудал тодорхойгүй байна.

- Шинээр боловсруулсан журамд судалгааны ажлын үр дүнг жил бүр үнэлдэг байна гэсэн хэдий ч оюутнууд болон удирдагч багш нарт үнэлгээний энэ шалгуур, зарчим тодорхойгүй байна.
- Удирдлагын мэдээллийн систем ашигладаг. Түүнийг сургалтын нэгдсэн алба хариуцдаг.
- Үнэлгээ, шалгалтын талаарх суралцагчийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг журамтай.

### **Шаардлага 3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх**

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг “эрдэм шинжилгээ, судалгааны багц цаг тооцоход баримтлах журам”, “магистрант, докторант шилжүүлэн суралцуулах журам”-д үндэслэн хүлээн зөвшөөрч, хичээлийн болон судалгааны ажлын багц цагийг дүйцүүлэн тооцдог.
- Суралцагчийн судалгааны чиглэлээр зайлшгүй судлах шаардлагатай мэргэшүүлэх хичээл ОТИС-д заагддаггүй бол удирдагч багшийн зөвшөөрлөөр ОТИС-тай гэрээтэй магадлан итгэмжлэгдсэн их сургууль, үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хүрээлэн, төвд 6 кр цагийг судлан тооцуулдаг бөгөөд дүнг тухайн байгууллагаас албан ёсоор ирүүлсэн багц цаг, дүнгийн тодорхойлолтыг үндэслэн тооцдог.
- Дүн үнэлгээ, багц цаг тооцуулахтай холбогдох асуудлыг гэрээний дагуу шийдвэрлэдэг байдал нь суралцагчийн эрх ашигт нийцсэн.
- 7 докторантын суралцахуйн үр дүнг тооцсон байгаа нь тайланд дэлгэрэнгүй орсон.

#### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

##### **Дүгнэлт:**

- Багц цагийг дүйцүүлэн тооцдог журамтай. Үнэлгээний журамтай. Журмын дагуу үйл ажиллагааг явуулдаг байна.
- Судалгааны ажлын үнэлгээ оролцогч талуудад тодорхой байх шаардлагатай.

### Шаардлага 3.3 Докторантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн нэмэлт арга хэмжээ, үйл ажиллагаанд докторантыг оролцуулдаг байна. Эдгээр арга хэмжээ, үйл ажиллагаанд докторантыг оролцуулах, баталгаажуулах, үнэлүүлэх тогтолцоотой байна.

#### Баримт нотолгоо:

Докторантыг дэмжих, зөвлөгөө өгөх байдлыг дараах зүйлсээр нотолж байна.

- Судалгааны ажлыг эрчимжүүлэх үүднээс эрдмийн зөвлөлийн гишүүд, зөвлөх профессор багш нараас бүрдсэн, өргөтгөсөн зөвлөл хурлыг зохион байгуулж, докторантуудын судалгааны ажлын явц, үр дүн, бүтэц, онол, арга зүйг хэлэлцэн, зөвлөгөө өгдөг.
- Эрдэм шинжилгээний төлөвлөгөөт семинар, их семинарт оролцсон, туршилт судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнг эрдэм шинжилгээний семинар, хуралд илтгэж хэлэлцүүлсэн, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлэх зэргээр Эрдэм шинжилгээний багц цагийг тооцдог.
- Докторантууд ашиглах судалгааны төв байгуулан ажиллуулж байна. ЭШСТ-өөс зохион байгуулж буй сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт үнэ төлбөргүй хамрагддаг.
- Эрдэм шинжилгээний хурал, судалгааны программын сургалт, магистрын ажил удирдуулах замаар докторантуудын оролцоог дэмждэг.
- Докторын хөтөлбөрийн хамтын ажиллагааг өргөжүүлж, Сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулан БНХАУ-ын Линонингийн их сургуультай гэрээ байгуулан засгийн газрын 100% тэтгэлэгт жил бүр хамруулж байна. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, 4 докторант 100% тэтгэлгээр суралцаж байна.
- ЭШСТ-д эрдэм шинжилгээний нээлттэй эх сурвалжийг ашиглан судалгаа хийх боломжтой, зааврыг суралцагчдад зориулан гаргасан.
- ЭШСТ-д Smart PLS болон SPSS програмуудыг ашиглан судалгаа хийх, мэргэжлийн багшаас зөвлөгөө авах бүрэн боломжтой бөгөөд тус төв нь орон тооны эрхлэгчтэй.
- Докторант суралцаж буй чиглэлээсээ өөр 6 кр хичээлийг сонирхлын дагуу өөр их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, шинжлэх ухааны академиас сонгон судалж болно. Энэ нь мэргэших хичээлийн багц цагт тооцогддог байна.
- Эрдэм шинжилгээний төлөвлөгөөт семинар, их семинарт оролцсон, туршилт судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнг эрдэм шинжилгээний семинар, хуралд илтгэж хэлэлцүүлсэн, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлэх зэргээр Эрдэм шинжилгээний багц цагийг тооцуулж болно.
- Сургууль хоорондын гэрээний дагуу гадаадад тэтгэлэгтэй сургалтад хамрагдах боломжтой.
- Олон улсын хэмжээнд зохион байгуулж тогтмолжсон эрдэм шинжилгээний хурал, симпозиум, форум, семинар-8, улсын хэмжээнд зохион байгуулж тогтмолжсон эрдэм шинжилгээний хурал, семинар-17, сургуулийн хэмжээнд зохион байгуулж тогтмолжсон эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг-25 байна. Уламжлалт арга хэмжээ болж тогтмолжсон эрдэм шинжилгээний хурлаас эрдэм шинжилгээний баримт бичгийн эмхэтгэл болгон нийтлүүлсэн бүтээл-5 байна.

## **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Дүгнэлт:**

- Нэмэлт сургалт зохион байгуулдаг
- Эрдэм шинжилгээний семинар, хуралд оролцуулдаг
- Судалгааны ажлаа хийх бүрэн тоног төхөөрөмжтэй, SPSS, SMART PLS3.0 сүүлийн үеийн чанарын судалгааны программуудыг суулгасан.

### **Шаардлага 3.4 Судалгааны санхүүжилт**

Докторын судалгааг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах ил тод бодлого, журамтай байна. Энэ нь сургуулийн судалгааны бодлого, зорилготой нийцсэн байна.

### **Баримт нотолгоо:**

- Сургуулийн хувьд нэгдсэн санхүүтэй бөгөөд ойрын болон дунд, урт хугацааны зорилтуудаа ханган ажиллах, сургалтын орчныг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх, багш, ажилтан, оюутнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн тулд санхүүгийн шаардлагатай нөөцийг бүрдүүлж ажилладаг.
- Орлогын гол эх үүсвэр нь сургалтын төлбөр 90%, бусад үйл ажиллагааны орлого 10%-аас бүрдэж байна. Сургалтын төлбөрийг мэргэжлийн хөтөлбөр бүрээр жил бүр ОТИС-ийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталдаг.
- Элсэлт бага байгаатай холбоотой сүүлийн 3 жил тус хөтөлбөрийн төлбөр нэмэгдээгүй байна.
- Эрдэм шинжилгээний тогтмолжсон хурал болон бусад зохион байгуулагдсан арга хэмжээнд (форум, симпозиум, семинар гэх мэт), 21000000 төгрөгийг докторын зэрэг амжилттай хамгаалсан багш нарын эрдмийн бүтээлийн ажлыг урамшуулахад, 102096076 төгрөгийг ном сурах бичиг, эрдэм шинжилгээ судалгааны үр дүнгийн эмхэтгэлийг худалдан авахад, 8850000 төгрөгийг магистр, докторын сургалтын төлбөрийг хөнгөлөхөд, 7240000 төгрөгийг дотоод төслийн хэлбэрээр судалгааны ажлыг дэмжихэд, 127899000 эрдэм шинжилгээ, судалгааны төв, оюутны бие даан суралцахад зориулагдсан төв байгуулагдахад зарцуулагдсан байна.

## **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Дүгнэлт:**

- Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, ном материал худалдан авах, эрдмийн бүтээлийн урамшуулалт, төлбөр хөнгөлөлт, дотоодын төсөл зэргээр судалгааг санхүүжүүлдэг
- Докторын судалгааг санхүүжүүлэх журам байхгүй
- Бусад эх үүсвэрээс судалгааны санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх боломж хомс
- Боловсрол судлалын докторын хөтөлбөр нь өөрийн санхүүжилтийн хувьд алдангитай ч нийгмийн оролцоог дэмжих зорилгоор тус хөтөлбөрийг хэрэгжүүлсээр байна.

- Сургууль өөрөө санхүүжлэн хэд хэдэн судалгааны төсөл хэрэгжүүлсэн байна.
- Сургуулийн хувьд үндэсний болон бүс нутгийн төвшинд судалгааны төслүүдэд оролцох байдлыг дэмжих шаардлагатай.

### **Шаардлага 3.5 Сургалтын тэтгэлэг**

Докторантын сургалтыг санхүүжүүлэх, тэтгэлэг олгох санхүүгийн эх үүсвэрийг тодорхой заасан дүрэм журамтай байна.

#### **Баримт нотолгоо:**

- Докторантын сурч боловсрох, судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэх, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй суралцагчийг урамшуулах, шилдэг элсэгчдийг дэмжих зорилгоор тэтгэлэг олгодог бөгөөд сургалтын төлбөрийн зардлын тодорхой хэсгийг мөнгөн болон бусад хэлбэрээр (сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тодорхой багц цагийн төлбөрөөс чөлөөлөх гэх мэт) санхүүжүүлэхэд буцалтгүй тусламж хэлбэрээр олгодог.
- Суралцагчид олгох тэтгэлгийн үйл ажиллагааг “ОТИС-ийн оюутанд тэтгэлэг олгох, хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх журам”-аар зохион байгуулдаг.
- Докторын тэтгэлэгт хөтөлбөр нь сургуулийн сонгон шалгаруулалтад тэнцсэнээр Тайваны Минь Чуаны ИС, БНХАУ-ын Линаонингийн ИС-тай албан ёсны гэрээтэйгээр докторын хөтөлбөрт тэтгэлгийг олгож ажилладаг. Гэрээний дүнд 3-4 жилийн турш сургалтын төлбөр, дотуур байрны зардлаас чөлөөлөгдөн, сар бүр амьжиргааны зардлаа авч суралцах давуу боломжийг олгодог.
- Сүүлийн 5 жил ахисан шатны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан төгсөгчдийн тоон үзүүлэлт нэмэгдэж 5 докторант 80-100%-ийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, 15 докторантад 26,643,500 төгрөгийн бодит тэтгэлгийг олгосон байна.

#### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

##### **Дүгнэлт:**

- 5 докторант 80 – 100%-ийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж 15 докторантад 26.643.500 төгрөгийн бодит тэтгэлгийг олгосон байна.
- Элсэн суралцагчдад түрүүлж бүртгүүлсэн тохиолдолд хөнгөлөлт үзүүлдэг байна.
- Бусад бизнесийн байгууллагууд болон төр захиргааны байгууллагын зүгээс суралцагчдад тодорхой хөнгөлөлт үзүүлдэг гэсэн боловч хэрхэн, ямар арга замаар хөнгөлөлт үзүүлдэг талаарх мэдээлэл нь хангалтгүй.
- Эдгээр нь сурлагын амжилт, суралцахуйн үр дүнг дэмжин, хөгжүүлж байгааг хэрхэн үнэлж, баталгаажуулдаг нь тодорхойгүй
- Докторантыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр ерөнхийдөө хангалтгүй.

### **Шалгуур 3. Шинжээчийн үнэлгээ:**

- Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй. Дүн үнэлгээг сургалтын программаар хянадаг.



- Судалгааны шинжилгээний ажлыг хийж, хэрэгжүүлэх, дэмжих, хөгжүүлэх нөхцөл бүрдсэн
- Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг цогцоор үнэлэх шалгалтын материалын санг хичээл бүрээр боловсруулан ашигладаг.
- Амжилттай суралцахад нь зөвлөн тусалж ажиллах судалгааны профессорын багтай. Ажиллах журамтай.
- Докторантуудын судалгааны ажлын явц үр дүнг хэлэлцэхэд анхаарч эрдэм шинжилгээний их семинар, эрдэм шинжилгээний хурлууд тогтмолжсон.

### **Шалгуур 3. Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг бүрэн хангасан**

Тус сургууль нь хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байх шаардлагыг **бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

### **Шалгуур 3. Зөвлөмж:**

- Олон улсын нийтлэг зарчим /Зальцбургийн зарчим/ -д нийцүүлэн үнэлгээний арга зүйг нарийвчлан боловсруулж, мөрдөх
- Оюутны хандлагыг үнэлэх үнэлгээний үзэл баримтлал, шалгуур шаардлагыг тодорхой болгох
- Тус хөтөлбөрийн хүрээнд олон улсын судалгаа шинжилгээ, хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Докторын хөтөлбөрөөр суралцагчдад зориулсан тэтгэлгийг нэмэгдүүлэх
- Судалгааны санхүүжилтийн шинэ боломж, эх үүсвэрийг эрэлхийлэх
- Судалгааны санхүүжилт болон докторын хөтөлбөрөөр суралцагчдад тэтгэлэг олгох шалгуур, шаардлагыг шинэчлэх, сайжруулах
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн үүргийг зөвхөн хэрэгжсэн арга хэмжээнүүдийн үр дүнг дүгнэхэд бус үйл ажиллагааг төлөвлөх шатанд нь хүрэх үр дүн, хэмжих нэгж, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлдог тогтолцоог бий болгох

### **ШАЛГУУР 4. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН**

***Докторын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.***

#### **Шаардлага 4.1 Багшийн нөөц**

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, оюутны тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна.

#### **Баримт нотолгоо:**

- БСШУ-ны сайдын 2003 оны 139 тоот тушаалын хавсралт 1-ээр баталсан Их сургуулийн багшийн албан тушаалын орон тоонд тавих нийтлэг шаардлагыг мөрдөн ажиллаж байна.
- Хүний нөөцийн бодлогын баримт бичигтэй. /2016 оны 03-р сард батлагдсан/



- Тухайн хичээлийн жилийн шаардлагатай орон тоог Удирдах зөвлөлөөс тогтоож захирлын тушаалаар баталж мөрддөг. Багш сонгож авах хэрэгцээ нь сургуулийн хэрэгжүүлж буй хөтөлбөр, тухайн хичээлийн жилийн бодлого, төлөвлөлтөд үндэслэдэг.
- Докторын хөтөлбөрт ажиллах багшид тавигдах шалгууртай.
- Докторын хөтөлбөрт багшилж байгаа багшлах бүрэлдэхүүнд МУ-ын гавьяат багш 2, Шинжлэх ухааны доктор 1, Боловсролын доктор 12 ажиллаж байна.
- Докторын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг багшийн тоо 15 үүнээс үндсэн багш 13, зочин багш 1 мэргэжилтэн багш 1 байгаа ба 86.7% нь үндсэн багш байна.
- Нэг багшид ногдох оюутны тоо 4 байна.

### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

- Чадварлаг багш, судлаачийн нөөцийг бүрдүүлэх чиглэлээр бодлого, төлөвлөлт тодорхой байна. Зураглал 4.1.1
- Тодорхой хэмжээний багшийн нөөцтэй /Хүснэгт 4.1.1/
- Докторын сургалтад магистр зэрэгтэй 1 багш хичээл ордог ба энэ нь Оюуны өмч” хичээлийг заадаг Оюуны өмчийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн судлаач юм.
- Багшийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар авч буй арга хэмжээ тодорхойгүй
- Докторын хөтөлбөрт хичээл орж байгаа Магистр багш 6% -ийг эзэлж байгаа ба энэ нь тухайн мэргэшлээр тухайлбал оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оюуны өмчийн эрх зүй хичээлийг ордог байна.
- Докторын хөтөлбөрт багшлах бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх, бусад их дээд сургууль болон судалгааны байгууллагуудын төлөөллийг оролцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулах, нэг багш олон хичээл заадаг байдлыг өөрчлөх хэрэгтэй.

#### **Шаардлага 4.2 Багшийн хөгжил**

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, докторын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, докторын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлдэг байдлыг дараах зүйлсээр нотолж байна.

- “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” 2018-2022 он хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байгаа.
- Багшийн хөгжлийн төвтэй. Тус төв нь багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх ур чадвараа ахиулахад чиглэсэн сургалтуудыг сургалтын төлөвлөгөөний дагуу тухайн чиглэлээр мэргэшсэн багш, судлаачдаар дамжуулан явуулдаг байна.
- Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа нь албажсан. Тус төвийн ажиллах дүрэмтэй, хариуцсан төвийн эрхлэгчийг томилон албан ёсоор ажиллуулж байна.
- Багшийн судалгааны бүтээлүүдийн тоо, чанарт ахиц гаргахад чиглэсэн журамтай. /Дүрэм журмын эмхэтгэл х186, 197/

- Багшийг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. /ОТИС-ийн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр/
- Тус сургууль нь багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоосон ба мэргэжлийн ур чадварын талаарх тухайлсан шаардлагыг ОТИС-ийн багшийг сонгон шалгаруулах журамд заасан байна.
- Өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж байгаа ба 2018 онд “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулан 2019 оны 1 сард багшийн хөгжлийн төвийг байгуулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

- Багшийн сонгон шалгаруулах журамтай. Багшид тавигдах шаардлага, шалгуур маш тодорхой, багш сонгон шалгаруулах процессын албан ёсны зураглалтай. Түүний дагуу үйл явцыг хянаж баталгаажуулдаг байна.
- Багш сонгон шалгаруулж авах журамд өргөн хүрээнд судалгаа хийх чадвартай байдал болон судалгааны байгууллагуудтай хамтран ажилладаг байх гэсэн шаардлагуудыг багтааж оруулах хэрэгтэй.
- Өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж байгаа ба 2018 онд “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулан 2019 оны 1 сард багшийн хөгжлийн төвийг байгуулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна.
- Тухайн хөтөлбөрийн удирдагч багшийн хөгжил тодорхойгүй байна.
- Докторын хөтөлбөрт хичээл зааж байгаа болон докторантын ажил удирдаж буй багш нарыг манлайллын болон чадавхийг нэмэгдүүлэх сургалтууд зохион байгуулах хэрэгтэй.

#### **Шаардлага 4.3 Судалгаа ба хөтөлбөрийн хөгжил**

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажил хийдэг, үр дүнг хөтөлбөрийн багшлахуй ба суралцахуйд тусгахын зэрэгцээ шаардлагатай тохиолдолд докторантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Боловсрол судлалын докторын хөтөлбөрт тавигдах шаардлагыг Сайдын А/370-р тушаалын дагуу хөтөлбөрийн бүтэц, зарчим, элсэгчдэд тавих шаардлага, эзэмшүүлэх мэдлэг, ур чадвар, хандлага, үнэлгээ зэргүүдийг боловсронгуй болгоход чиглэн ажилласан.
- Боловсрол судлалын докторантурын хичээлийг ганцаарчилсан болон бүлгийн хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулж сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, багш, суралцагчийн холбоо харилцааг сайжруулах чиглэлээр дидактикийн семинарыг тус хөтөлбөрийн хүрээнд нийт багш нарын дунд зохион байгуулсан.
- Хичээлийн тодорхой нэг сэдвийн агуулгыг багтаамжаар нь хэрхэн судалж тодорхойлох үйл ажиллагааны онол аргазүйн асуудлыг судалж, үр дүнгээр нь багш суралцагчийн субъект-объектын болон субъект-субъектийн харилцааны загвар схем боловсруулсан байна.
- Боловсрол судлалын докторын хөтөлбөрийг МУИС, МУБИС зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч томоохон их сургуулиуд, хувийн хэвшлээс Орхон ИС-ийн сургалтын хөтөлбөртэй харьцуулан сайжруулалт хийсэн.

- Гаднын улс орнуудаас Европын холбооны улсуудын их дээд сургуулиуд / C3QA төслийн хүрээнд хамрагч улсууд болох Испани, франц, Польш/ болон ОХУ, БНХАУ-ын хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийгдэж байгаа.

### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

- Хичээлийн үйлийн судалгаа хийх чиглэлээр тэргүүн туршлагыг хөтөлбөр хэрэгжүүлэхэд хэрэглэж байгаа
- Хөтөлбөрийг сайжруулах чиглэлээрх докторантуудын оролцоо тодорхойгүй байна.
- Тухайн хөтөлбөрийн хөгжлийн судалгаа хомс байна.
- Сонгон судлах хичээлийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.
- Багшлах бүрэлдэхүүний нөөц боломжийг харгалзан хичээлүүдийг модульчлан зохион байгуулах боломжийг судалж, нэвтрүүлэх хэрэгтэй.

#### **Шалгуур 4. Шинжээчийн үнэлгээ:**

- Багшлах боловсон хүчний залгамж холбоо, нөөцийг бүрдүүлэх тогтолцоотой.
- Багшийн хөгжлийн хөтөлбөртэй. Багшийн хөгжлийн төвтэй.
- Хөтөлбөрийн хүний нөөцийн талаарх бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлж, сургуулийн стратеги төлөвлөгөөнд хүний нөөцийг хөгжүүлэх зорилго чиглэл тусгагдсан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн нөөц болон сургалтын таатай материаллаг орчин бүрдсэн.
- Багш болон суралцагчид судалгаа шинжилгээний ажлыг хийж хэрэгжүүлэх, тэдгээрийг дэмжих эрх зүйн орчин бүрдсэн.
- Багшийн хөдөлмөрийг үнэлэх зөв оновчтой тогтолцоог бий болгосон байна.
- Хүний нөөцийн бодлогын баримт бичигтэй.
- Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих үүднээс докторант багш нарын сургалтын цагийг хөнгөлж, бүтээлийн чөлөө олгох, докторантурт суралцахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, журмын дагуу эрдэм судлалын ажил хийж боловсролын докторын зэрэг хамгаалсан бол 3 сая, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан бол 5 сая төгрөгийн бодит урамшуулал олгох зэргээр санхүүгийн дэмжлэг, урамшуулал үзүүлэхийг журмаар зохицуулан ажиллаж байна.

#### **Шалгуур 4. Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг бүрэн хангасан**

- Докторын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байх **шалгуурыг бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

#### **Шалгуур 4. Зөвлөмж:**

- Удирдагч багш, докторантын хамтарсан судалгааны өгүүлэл хэвлүүлэх, хамтарсан судалгааны ажлыг эрчимжүүлэх
- Олон улсын нийтлэг шалгуур шаардлага (Salzburg principles, ESG, AACSB standards) –д нийцүүлэн докторын хөтөлбөрийн багш нарыг үнэлэх, хөгжүүлэх бодлого, журмыг сайжруулах
- Удирдагч багш нарын хэлний боловсрол, чадавхыг дээшлүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх

- Мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх өгүүллийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах, хэвлүүлсэн өгүүллийн чанарын ялгаа, үнэлгээний, дэмжлэгийн бодлого хэрэгжүүлэх

## **ШАЛГУУР 5. НӨӨЦ БА УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ**

***Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн талаар шийдвэр гаргахад шаардлагатай удирдлага мэдээллийн нэгдсэн системтэй байна***

### **Шалгуур 5.1 Сургалт, судалгааны орчин**

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр докторант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлсэн байна. Суралцагч эдгээрийг чөлөөтэй ашиглах боломж бүрдүүлсэн байна.

#### **Баримт нотолгоо:**

Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт, судалгааны орчныг бүрдүүлсэн байдлыг дараах зүйлсээр нотолж байна.

- ОТИС нь өөрийн гэсэн хичээлийн 3 байртай тул сургалтын орчин сайн бүрдсэн байна. Докторын хөтөлбөрт зориулсан эрдэм шинжилгээ судалгааны иж бүрэн тоног төхөөрөмжтэй төв, нийгмийн судалгааны төв, докторантуудад зориулсан мини номын сантай бие даалтын төвийг байгуулан ашиглаж байгаа нь сургалт, судалгааны орчныг бүрдүүлсэн байгааг харуулж байна.
- Сургалт, судалгааны танхимуудад ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгааг тогтмол гарган жил бүр сайжруулалт хийх, өндөр хурдны интернэтэд холбон ажиллаж байгаа зэрэг нь нотлох баримтаар батлагдлаа.
- Тоног төхөөрөмж дээр хэрхэн ажиллах талаар зааварчилгаа болон тоног төхөөрөмжийн ашиглалтыг бичдэг карт хөтлөн ажилладаг.

**Шинжээчийн үнэлгээ:** Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын сургалт судалгааны орчныг зохих шаардлагын дагуу бүрдүүлсэн байгаа тул тус шалгуурыг **бүрэн хангасан** байна

#### **Дүгнэлт:**

- Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх орчинг сайжруулах талаар хийсэн ажлууд тодорхой байгаа ба холбогдох нотлох баримтууд байна.
- Тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хариуцан ажилладаг мэдээллийн технологийн ажилтантай.
- Ашиглалтын карт хөтөлдөг.
- Интернетийн хурдыг нэмэгдүүлэх шаардлагатай, одоогоор харьцангуй бага байна (24 МВ).
- Орчин үеийн олон улсын судалгааны орчинг бүрдүүлэх зорилго тавин ажиллах шаардлагатай.

## Шаардлага 5.2 Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн ашиглах орчин бүрдүүлсэн ба судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр ашиглах боломж бүрдүүлсэн байна.

### Баримт нотолгоо:

Сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн ашиглах орчин бүрдүүлсэн ба судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр ашиглах боломж бүрдүүлсэн байгааг дараах зүйлсээр нотолж байна.

- Сүүлийн 5 жилийн байдлаар нийт фонд бүрдүүлэлтэд зарцуулсан мөнгөн хөрөнгө нь 2.1 дахин нэмэгдсэн.
- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглагдах ном, бүтээл, сурах бичиг, гарын авлага зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний фонд бүрдүүлэлт, баяжуулалтыг хийхдээ тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу мэргэжлийн тэнхим, мэргэжлийн багш, хөтөлбөрийн хороодын санал, судалгаанд үндэслэн улирал тутам хийдэг.
- Сургуулийн номын санд байхгүй болон цөөн тоотой ном, Монголын эрдэмтдийн бүтээл, судалгааны материалыг Монгол Улсын Үндэсний номын сангийн <http://nationallibrary.mn/mn/> веб сайт руу хандаж ашиглах, сургуулийн ном солилцооны гэрээний дагуу ашиглах боломжийг бүрдүүлсэн.
- “СТЕППЕЛИНК ХХК”-тай хамтран **Esan** цахим номын сангийн программыг нэвтрүүлээд байна. Үүний үр дүнд тус санд байгаа бүхий л бүтээлүүдийг ашиглах, эшлэл авах цаашлаад бүтээлийг нэгдсэн сангаас эх сурвалжуудтай харьцуулж давхардлыг тооцон үнэлгээ өгч, давхардсан эх сурвалжийн мэдээллийг харуулах хуулбар шалгах боломжтой болсон.
- Докторантын судалгаа, шинжилгээний ажилд ашиглах, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор МНСК-д 2012 онд гишүүнчлэлээр элсэн нээлттэй эхийн программуудыг ашиглахаас гадна докторант, багш нарт зориулсан ном зүйн программ Zotero, end note, mendeley зэргийг хэрхэн ашиглах, хайлтын системд хэрхэн ажиллах талаар сургалтуудыг хамтран зохион байгуулсан байна.

### Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

#### Дүгнэлт:

- Хуулбарлалтын программыг бий болгож байгаа.
- Докторын хөтөлбөрт ашиглагдах ном сурах бичиг, тухайн хичээлийн жил бүр докторын зэрэг хамгаалсан дипломын ажлыг цаасан болон CD хэлбэрээр ашиглуулдаг.
- Боловсрол судлалын чиглэлээр нээлттэй эхийн программуудыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах
- Хичээл тус бүрээрх сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн тодорхойгүй
- Байгаа эх сурвалжуудыг докторант хэрхэн ашиглаж буй байдал тодорхойгүй.
- Боловсролын чиглэлийн сүүлийн үеийн сэтгүүл, ном сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх, олон улсын нэр хүндтэй, өндөр эрэмбийн

сэтгүүлүүдийг онлайнар ашиглах боломжийг судалж, нэвтрүүлэх хэрэгтэй.

### **Шаардлага 5.3 Удирдлагын мэдээллийн систем**

Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- 2017-2018 оны хичээлийн жилээс бүх түвшний сургалтдаа кредит системийг бүрэн нэвтрүүлсэн.
- Удирдлагын мэдээллийн систем нь багш, профессорууд сургуулийн хэмжээний хүний нөөцийн систем, цалингийн программ, санхүүгийн программ, сургуулийн бүртгэлийн нэгдсэн систем, элсэлтийн нэгдсэн программ, багш оюутны веб, номын сангийн программыг нэгтгэн хичээлийн бүртгэл, цахим журнал, сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр авах, мэдээллийг баяжуулан, бүхий л тайлан мэдээг боловсруулан гаргах боломжтой.
- Удирдлагын мэдээллийн систем нь вебд суурилсан ба багш, ажилтан, суралцагчид болон удирдлагууд ашигладаг ба бүрэн үйл ажиллагааг сургалтын нэгдсэн алба хариуцан ажиллаж байна.
- Удирдлагын мэдээллийн системээр сургалтын чанар, ахиц дэвшил, өөрчлөлтийг хамаарах нэгжид нээлттэйгээр танилцуулж, үр дүнг хөтөлбөрийн сайжруулалт, сургалтын төлөвлөгөөнд тусгах чиглэлээр ашигладаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

- Удирдлагын мэдээллийн системтэй
- Бүртгэл, элсүүлэх үйл явц, сэтгэл ханамжийн судалгаа зэргийг онлайнар зохион байгуулдаг
- Ашиглалт, үр дүнгийн байдал тодорхойгүй
- Оролцлогч талуудаас ярилцлагын хэлбэрээр судалгаа авдаг байдлыг өөрчлөх хэрэгтэй.

### **Шаардлага 5.4 Мэдээллийн ил тод байдал**

Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцагчийн үнэлгээний аргачлал зэрэг мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

Тухайн хөтөлбөрийн талаарх иж бүрэн мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байдлыг дараах зүйлсээр нотолж байна.

- Тухайн хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэн [www.otgontenger.edu.mn](http://www.otgontenger.edu.mn) албан ёсны сайтаар мэдээлэл түгээдэг.
- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгөх 4 хүний бүрэлдэхүүнтэй сургалтын нэгдсэн алба ажилладаг ба байнгын үйл ажиллагаатай 11-453944 утсыг ажиллуулж байна.
- [info@otgontenger.edu.mn](mailto:info@otgontenger.edu.mn), [teachers@otgontenger.edu.mn](mailto:teachers@otgontenger.edu.mn) болон албан ёсны пэйж хуудсаар дамжуулан хөтөлбөрийн талаарх сонирхсон мэдээлэлд шууд хариулах веб админ ажиллаж байна.
- <http://student.otgontenger.edu.mn> вебээр тухайн хөтөлбөрөөр суралцагч нь өөрийн кодоор нэвтрэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй танилцах, багц цагийн мэдээлэл авах боломжтой.
- Докторын оюутнуудад зориулсан гарын авлагад элсэлтээс төгсөлт хүртэлх бүхий л мэдээллийг оруулсан байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

- Докторант оюутнуудын мэдээлэл, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө багшийн мэдээлэл болон бусад мэдээлэл удирдлагын мэдээллийн системдээ бүрэн орсон байна.
- Вэб хуудсын динамик байдлыг хангаж, докторантуудад бүх төрлийн мэдээллэр хангагдах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Дата санг өргөжүүлж, ашиглалтын нэмэгдүүлэх шаардлагатай.
- Ашиглалт ямар байгаа нь тодорхой бус

#### **Шаардлага 5.5 Төсөв санхүүжилт**

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

**Баримт нотолгоо:**

- Тус сургууль нь нэгдсэн төсөвтэй бөгөөд бүтцийн сургууль бие даан төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэхгүй харин хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь төсөвт санал оруулах, үндэслэл, захиалга, шаардлага хэрэгцээний судалгаа гаргаж шаардлагатай техник хэрэгсэл, материаллаг зүйлсийг авч ашиглах, асуудлыг шийдвэрлэхэд оролцох, шаардлагатай төсвийг ОТИС-ийн захирлаар батлуулан зарцуулдаг журамтай.
- Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн сургалтын төлбөр сүүлийн 3 жилд тогтмол байсан ба энэ нь элсэгч, суралцагчдын тоо цөөн байгаатай холбоотой.



## Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Дүгнэлт:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь сургалтын төлбөр бөгөөд төлбөрийн хэмжээг тухайн үеийн инфляцын түшингээс хамаарч жил бүр шинэчлэн ОТИС-ийн Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталдаг.
- Тухайн хөтөлбөрөөр суралцагчийн сургалтын төлбөрийн орлого нь зардлаа нөхөх боломж дутмаг тул бусад хөтөлбөрийн орлогоор зардлаа нөхөж байна.

### Шалгуур 5. Шинжээчийн үнэлгээ:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын орчныг бүрэн хангасан.
- Сургуулийн барилга байгууламж, анги танхимын хувьд жил бүр урсгал болон их засвар хийж, хэрэгжилтээ хянадаг.
- Сургуулийн техник, тоног төхөөрөмжийг ашиглалтын судалгааг үндэслэн шинэчлэн сайжруулдаг.
- Хөтөлбөрийн материаллаг баазыг нэмэгдүүлэх, шинэчлэн сайжруулах талаар хичээлийн жилийн эцэст мэргэжлийн тэнхимээс захиалга болон саналыг авч шийдвэрлэдэг.
- Удирдлагын мэдээллийн системд докторантуудын мэдээлэл бүрэн орсон. Түүнийг багш, суралцагч сургалтын үйл ажиллагаанд тогтмол ашиглаж, мэдээлэл авдаг.
- УМС-ийн бүрэн үйл ажиллагааг СНА хариуцан ажилладаг.
- Мэдээллийг ил тод шуурхай хүргэн ажилладаг. 4 хүний бүрэлдэхүүнтэй Маркетингийн алба ажилладаг.

### Шалгуур 5. Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг бүрэн хангасан

Тус сургууль нь суралцахуйн үйл ажиллагаанд шаардагдах материаллаг нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн талаар шийдвэр гаргахад шаардлагатай удирдлага мэдээллийн нэгдсэн системтэй байх **шалгуурыг бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

### Шалгуур 5. Зөвлөмж:

- Цахим сан, нээлттэй эхийн программуудын ашиглалтын байдлыг сайжруулах
- Номын сангийн орчныг сайжруулах, орчин үеийн чиг хандлага, шаардлагад нийцсэн, өөртөө үйлчлэх орчинг бүрдүүлэх
- Номын сангийн үйл ажиллагаанд чөлөөт сонголтын хэлбэрийг боловсронгуй болгох
- Гаднын захиалгат болон бусад байгууллага, иргэдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулж орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх

## ШАЛГУУР 6. ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

**Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.**



## **Шаардлага 6.1 Дотоод чанарын баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөлтийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэцтэй, үйл явцад бүх талуудын оролцдог байна.

### **Баримт нотолгоо:**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг байнга хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой ба үйл явцад бүх талуудын оролцоог ханган ажилладаг болохыг дараах зүйлээр нотолж байна.

- Европын холбооны Эрасмус плас төслийн хүрээнд хэрэгжиж буй докторын хөтөлбөрийг Олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд /интернациональчлах/ чиглэсэн оновчтой чанарын баталгаажуулалтын тогтолцоог бий болгон хэрэгжүүлэх зорилго бүхий C3QA /cycle 3 Quality Assurance/ төслийг Монголын Улсаас БСШУСЯ, БМИУЗ, МУИС-тай хамтран хэрэгжүүлж байгаа. Уг төсөлд Монгол улсаас гадна Испани, Франц, Армен, Украин, Польш, Какахстан улсуудын Боловсролын яам, Магадлан итгэмжлэлийн байгууллага, их дээд сургуулиуд нийт гэсэн 21 байгууллага оролцож, харилцан туршлага солилцон хэрэгжүүлж байгаа нь докторын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангаж, Олон улсын жишигт нийцүүлэн ажиллаж байгаа нь онцлог давуу тал байсныг дурдах нь зүйтэй.
- Докторын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлагатай.
- Докторын хөтөлбөрт чанарын баталгаажуулалт хийх төлөвлөлттэй
- Хөтөлбөр боловсруулах, докторын сургалт явуулах, хамгаалах, төгсөлтийн бичиг баримт олгох гэм мэт бүхий л сургалтын үйл явцуудын зураглал хийгдсэн бөгөөд хэн, хэзээ, ямар журмын дагуу хяналт тавин ажиллаж, хэнд мэдээлэх бүх үйл явц тодорхой байгаа нь хөтөлбөрийн үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг байнга хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоо бүрдсэн байгааг харуулж байна.
- Хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалтыг хангах зорилгоор хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг хичээлийн жил бүр үнэлж байхаар журамд заасан бөгөөд энэ талаар чанарын судалгаанууд авагдаж, жил бүр тайлан гарсан байсан.
- Хөтөлбөрийн хороо хөтөлбөрийн сайжруулалтыг хийсэн талаар хурлын тэмдэглэлд тусгасан байна.

### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт тогтмолжсон.
- Чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх зураглал, үйл явцын нэгдсэн бүтэц, төлөвлөлттэй байгаа ба оролцогч талуудын оролцоог бүрэн ханган ажиллаж байна.

- Чанарын баталгаажуулалт хийх төлөвлөгөөг хөтөлбөртөө тусган оруулсан бөгөөд төлөвлөлтийн дагуу хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хийгддэг байна.
- Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, сайжруулах төлөвлөгөө гарган ажилладаг байна.

Сул тал: хөтөлбөрт нэгдсэн иж бүрэн үнэлгээ хийсэн байдал дутмаг бөгөөд ажил олгогч болон мэргэжлийн судалгааны байгууллагын оролцоо сул байна.

### **Шаардлага 6.2. Магадлан итгэмжлэл**

Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.

#### **Баримт нотолгоо:**

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг ханган үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг болохыг дараах зүйлсээр нотолж байна.

- Чанарын менежментийн тогтолцоо Олон улсын стандарт нэвтрүүлсэн
- Олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж гэрчилгээжсэн.
- Докторын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг Олон улсын стандарт ESG-д нийцүүлсэн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг хангах төсөлд хамрагдаж, тодорхой үр дүнг гарч МУ-д анх удаа докторын хөтөлбөрийн шалгуур батлагдаж, тэрхүү шалгуураар хамгийн анхны сургууль болон магадлан итгэмжлэлд орж байгаа нь олон улсын жишигт хүрэх хүсэл эрмэлзлийг харуулж байна гэж үзэж байна.
- Хөтөлбөрийн чанарыг хангах, хөндлөнгийн чанар баталгаажуулалтыг 5 жил тутам хийлгүүлж хөтөлбөрт сайжруулалт хийж байхыг Докторын сургалт эрхлэхэд баримтлах журмын 3.6.2-д заасан байна.

#### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг ханган үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг болох нь баримтаар нотлогдсон тул **шалгуурыг бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

### **Шалгуур 6. Шинжээчийн үнэлгээ:**

1. Чанарын дотоод баталгаажуулалтын механизмыг бүрдүүлэн тогтмол ажиллуулж хэвшсэн нь тус сургуулийн давуу тал юм.
2. Суралцахуйн үйл ажиллагаа болон багшлахуйн үнэлгээг санал асуулга аван нэгтгэн дүгнэдэг нь гарын авлага болон үйл явцын зураглал, удирдамж, тайлан зэргээс харагдаж байв.
3. Сургалтын үйл ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлээр суралцагчийн үнэлгээнд тулгуурлан өөрчлөлт хийх зорилго, түүнээс гарах боломжит үр дагавруудыг тодорхойлж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.
4. Хэрэглэгчдийн санал хүсэлт хүлээн авах шийдвэрлэх журамтай. Шийдвэрлэсэн талаар бүртгэл хөтөлөгдсөн.
5. Үндэсний болон ОУ-ын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлэл хийлгэсэн.

6. Чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан орон тооны ажилтантай, эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
7. Хөтөлбөрт оролцогч талуудын сэтгэл ханамжийг үнэлж, хөтөлбөрийн сайжруулалтад тусгадаг
8. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт нь европын стандартад нийцсэн шалгуураар чанарын хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэж байгаа нь Олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байна гэж үзэж байна.
9. Чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлагатай.
10. Чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоо бүрдэж, чанарын хөндлөнгийн баталгаажуулалтыг үе шаттай хийлгэдэг.

#### **Шалгуур 6. Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг бүрэн хангасан**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байх шалгуурыг бүрэн хангасан гэж дүгнэж байна.

#### **Шалгуур 6. Зөвлөмж:**

- Удирдагчийн багшийн үнэлгээг тогтмол хийн сайжруулах
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгоход хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим, хөтөлбөрийн дэд хорооны зүгээс чанарын баталгаажуулалтыг хийх төлөвлөлтийг оновчтой, тодорхой болгох
- Хөтөлбөрийн үнэлгээнд докторантуудын оролцоог нэмэгдүүлэх

## Г. ШИНЖЭЭЧИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ:

ОТИС-ийн Хүмүүнлэгийн сургуулийн Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багийн боловсруулж ирүүлсэн өөрийн үнэлгээний тайлантай БМИҮЗ-өөс томилогдсон үндэсний хэмжээний шинжээчдийн багийн гишүүд болон Олон улсын шинжээчдийн багийн гишүүд танилцаад дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа нь бүхэлдээ судалгааны чиглэлээр сургалт явуулж, докторантууд судалгааны ажил хийж, диссертац бичиж, хамгаалж төгсөхөөр боловсруулагдсан нь хөтөлбөрийн нэр, зорилго, боловсруулсан хөтөлбөрийн агуулгатай нийцэж байна.
2. Докторын сургалтын хөтөлбөрийн хороо түүний бүтэц бүрэлдэхүүн нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас гаргасан удирдамж чиглэлийн дагуу бүрдүүлсэн байна.
3. Хүний нөөцийн төлөвлөлт багшлах бүрэлдэхүүний хувьд ямар хичээлийг хэн гэдэг, ямар эрдмийн цол зэрэгтэй багш заах нь тодорхой заасан байна.
4. Сургалт явуулах орчин материаллаг баазын хувьд докторын түвшинд сургалт явуулах боломж бүрдсэн, докторантуудад зориулсан сургалт, судалгааны төвүүдийг зориулсан бий болгосон бөгөөд сүүлийн үеийн өндөр үзүүлэлттэй техник тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байдал нь давуу талтай байна.

№	Шалгуур	Дүгнэлт	Тайлбар /Шаардлага хангаагүй шалтгаан/
1	Хөтөлбөрийн зорилго, агуулга	Бүрэн хангасан	
2	Хөтөлбөрийн хэрэгжилт	Бүрэн хангасан	
3	Докторантын үнэлгээ, хөгжил	Бүрэн хангасан	
4	Багшлах бүрэлдэхүүн	Бүрэн хангасан	
5	Нөөц ба удирдлагын мэдээллийн систем	Бүрэн хангасан	
6	Чанарын баталгаажуулалт	Бүрэн хангасан	
	<b>НЭГДСЭН ДҮГНЭЛТ</b>	Магадлан итгэмжлэлийн шаардлагыг <b>бүрэн хангасан</b> гэж дүгнэлээ.	

## ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Отгонтэнгэр их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн “Боловсрол судлал” докторын хөтөлбөрийг Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлийн Удирдах Зөвлөлийн 2019 оны 04 сарын 02-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан “Докторын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ын шалгуур үзүүлэлтүүдийг **бүрэн хангасан** гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../Б.Жадамба/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг ...../Н.Оюунцэцэг/

## Хавсралт 1: Танилцсан нотлох баримтууд

Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримтын жагсаалт

### Шалгуур 2.1-ын нотлох баримт

- БСШУ-ны сайдын А/370 тоот тушаалын 2-р хавсралтаар баталсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”
- ОТИС-ийн ректорын 135 тоот тушаал, Магистр, докторын сургалтыг зохион байгуулахад баримтлах журам – дүрэм журмын эмхэтгэл 2017
- Докторын сургалтыг зохион байгуулахад баримтлах журам 2019
- Элсэлтийн комиссын тушаал 2016, 2017, 2018
- Элсэгчийн бүрдүүлсэн материал 2016-2019
- Элсэгчийг элсүүлсэн тушаалын хуулбар 2016-2019
- Элсэлтийн шалгалттай холбоотой цөм материал 2017-2019
- МА-ны төлөвлөгөө 2017, 2018, 2019
- Элсэлтийн үйл ажиллагааны зураглал

### Шалгуур 2.2-ын нотлох баримт

- Докторын сургалтын хөтөлбөр
- Багц цаг тооцуулах журам
- Ганцаарчилсан төлөвлөгөө
- Докторантурын гарын авлага
- ОТИС-ийн дүрэм журмын эмхэтгэл Х-119

### Шаардлага 2.3-ын нотлох баримт

- Профессорын хэлэлцүүлэг
- “Science safe” судалгааны хэлэлцүүлгийн мэдээлэл
- “Судлаачийн цаг” цуврал лекцийн мэдээлэл
- ОТИС-ийн эрдэм шинжилгээний баримт бичгийн эмхэтгэл

### Шаардлага 2.4-ын нотлох баримт

- ОТИС-ийн Ректорын 2016 оны 3-р сарын 21-ны өдрийн А/29 тоот тушаал
- Удирдагч томилсон ОТИС-ын захирлын шийдвэр
- Докторын диссертацийн сэдвийг баталсан бүтцийн сургуулийн захирлын шийдвэр
- Мэргэжлийн тэнхимээс гаргасан дипломын ажил, диссертацийн сэдвийн жагсаалт
- Ганцаарчилсан төлөвлөгөөний загвар

### Шаардлага 2.5-ын нотлох баримт

- Тэтгэлэгт хөтөлбөрт /гадаад улсад/ хамрагдсан төгсөгчдийн мэдээлэл
- Олон улсын болон үндэсний хэмжээний төсөл, ОТИС-ын захиалгат болон өөрийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн жагсаалт
- Цахим сангийн мэдээлэл
- Хамтын ажиллагаатай байгууллагуудын мэдээлэл
- Салбар түс бүрийн судалгааны ажлын тэргүүлэх чиглэл
- ОТИС-ийн судалгааны ажлын стандарт /CS110413:2018/

### Шаардлага 2.6-ын нотлох баримт

- Удирдагчаа үнэлэх үнэлгээний хуудасны загвар
- Докторын зэрэг хамгаалах үйл явцын зураглал
- ОТИС-ийн судалгааны ажлын стандарт /CS110413:2018
- Оюуны өмчийн гарын авлага
- Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм

#### Шаардлага 2.7-ын нотлох баримт

- Төгсөлтийн бичиг баримт олгох үйл явц
- Багц цаг дүүргэсэн тухай гэрчилгээний хуулбар
- Диплом, хавсралтын загвар
- Докторын ажлаа амжилттай хамгаалсан тухай докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн шийдвэр
- Докторын зэрэг олгох тухай ОТИС-ийн захирлын тушаал
- БСШУС-ын №480 тоот тушаалын хавсралтаар баталсан дээд боловсролын диплом олгох журам

#### Шаардлага 3.1-ын нотлох баримт

- ОТИС-ийн оюутны сурах үйл ажиллагааг үнэлэх журам, Дахин шалгалт өгөх, хичээлийг дахин судлах, нэмэлт багц цуглуулах журам
- ОТИС-ийн сургалтын хэрэглэгдэхүүн, судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага
- Суралцагчдын голч дүнгийн жагсаалт /хуулбар/
- Сургалтын мэдээллийн систем дэх дүн, мэдээлэл
- Сургалтын албанаас гаргасан хичээл, шалгалтын хуваарь
- ОТИС-ийн Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн дэд хорооны бүрэлдэхүүний тушаал, үйл ажиллагааны төлөвлөлт, үйл явц, хурлын тэмдэглэл

#### Шаардлага 3.2-ын нотлох баримт

- ОТИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл /Оюутны сурах үйл ажиллагааг үнэлэх журам, магистрант, докторантын багц цаг тооцуулахад баримтлах журам, магистрант, докторантыг шилжүүлэн суралцуулах журам/
- ОТИС-ийн ХС-ийн докторын ангийн оюутнуудын шилжилт хөдөлгөөний мэдээлэл
- ОТИС-д докторантад элсүүлэн суралцуулах болон шилжүүлэн суралцуулах тухай Ректорын тушаалууд
- Mobility-г дэмжсэн баталгаа: 7 докторантын шилжилтийн баримт бичиг /Б.Эрдэнэболор, Н.Эрдэнэбаяр-МУЭИС-с, Н.Хосбаяр-Испанийн Канарын ИС, Ж.Мөнхжаргал-Солонгост, Л.Сансармаа-Тайвань, О.Туул, С.Батцэцэг-БНХАУ Лиоанины ИС/
- ОТИС-ийн гадаадын их, дээд сургуультай хамтран ажиллах, оюутан солилцох, суралцуулах санамж бичиг, гэрээнүүд

#### Шаардлага 3.3-ын нотлох баримт

- Эрдмийн зөвлөлийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, зөвлөгөө
- Эрдэм шинжилгээний их семинаруудын тэмдэглэл, хөтөлбөр
- Гадаад, дотоодын ЭШХ-д оролцсон, илтгэл хэлэлцүүлсэн байдал
- Удирдагч багш нарын зөвлөгөө өгсөн цагийн хуваарь, тэмдэглэл
- Докторант, судлаачдад зориулсан сургалтуудын зар, хөтөлбөр, сертификат /Smart PLS, SPSS, ШУ-ны мэдээллийн санг ашиглах нь, Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй

- ЭШХ-ын хөтөлбөр, эмхэтгэл
- ЭШ-ний багц цаг тооцох журам
- ЭШ-ний ажлыг дэмжих, урамшуулах журам

#### Шаардлага 3.4-ын нотлох баримт

- ОТИС-ийн УЗ-ийн хурлын тэмдэглэл (Мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлбөр хэлэлцсэн)
- ОТИС-ийн санхүүжилтээс ЭШ-ний зардлын тооцоо /үүнээс ЭШ-ний хурал, семинар, форумд, Төсөл хөтөлбөрт, ЭШ-ний бүтээлд г.м./

#### Шаардлага 3.5-ын нотлох баримт

- ОТИС-ийн дүрэм журам /ОТИС-ийн оюутанд тэтгэлэг олгох, хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх журам/
- ОТИС-ийн санхүүжилтээс оюутанд олгосон тэтгэлэг, санхүүжилтийн зардлын тооцоо
- ОТИС-ийн оюутанд тэтгэлэг олгох асуудлаар хэлэлцсэн хурлын протокол
- МУ-ын хэмжээнд оюутан, суралцагчдад олгодог тэтгэлэг, санхүүжилтийн журам, зар
- Бусад тэтгэлгүүдийн мэдээлэл
- Гадаадын ИДС-ийн тэтгэлэгт хамрагдсан баримт, нотолгоо

#### Шаардлага 4.1-ын нотлох баримт

- ОТИС-ийн хүний нөөцийн талаарх баримтлах бодлого
- Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг ОТИС-ийн 2016 оны 03-р сард хамтын олны хурлаар хэлэлцүүлэн баталсан протокол
- Багш нарын хөдөлмөрийн гэрээ
- Ректорын 2012 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 156 тоот тушаалын 1-р хавсралтаар багш нарын албан тушаалын зэрэглэл, ангилал, шатлалыг баталсан
- Багш нарын хүний нөөцийн анкет
- Багш нарын ажлын байрны тодорхойлолт
- ОТИС-ийн багш сонгон шалгаруулах дүрэм журам, зураглал
- Багш нарын удирдлага мэдээллийн сан
- Багшийн үйл ажиллагаанд “Профессор багш нарын гүйцэтгэх ажлын хэмжээ, кредит цагийн норм тогтоох журам
- Багш нарын эрдэм шинжилгээний ажил, бүтээлийг урамшуулах журам
- Багш нарын үйл ажиллагаанд санхүүгийн хөшүүрэг хэрэглэх журам
- Урамшуулалт цалин олгох журам
- Багш нарыг аттестатчилах журам
- Багшийн ажлыг дүгнэх журам
- Оны шилдэг багш шалгаруулах журам
- Багш, суралцагчдад тэтгэмж тусламж үзүүлэх журам
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багшид тавигдах шаардлагыг хангасан байдал
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын цалингийн талаарх мэдээлэл

#### Шаардлага 4.2-ын нотлох баримт

- ОТИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр
- Багшийн хөгжлийн хэрэгцээний судалгааны тайлан
- Багшийн хөгжлийн төвийн жилийн төлөвлөгөө
- Багшийн хөгжлийн төвийн эрхлэгч томилсон тушаал

- Багшийн хөгжлийн төв үүсэн байгуулагдсанаас хойших хийгдсэн ажлуудын төлөвлөгөө, тайлан
- Багшийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан багш нарын нэрс, сертификатын хуулбар
- Багш нарын эрдмийн зэрэг цолны үнэмлэхийн хуулбар
- Багш нарын жилийн ажлын төлөвлөгөө, тайлан
- Багш нарын хувийн хавтас
- Багш нарын бүтээлийн жагсаалт
- Багш нарын мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлийн үнэмлэх

#### Шаардлага 4.3-ын нотлох баримт

- Багш нарын ном бүтээл гарын авлага (*Эх хувиараа*)
- Багш нарын гадаад болон дотоодод хэвлүүлсэн өгүүлэл бүхий сэтгүүл (*Багшийн хувийн хавтсанд*)
- Багш нарын олон улсын болон үндэсний хэмжээнд оролцсон хурлын урилга, хөтөлбөр (*Багшийн хувийн хавтсанд*)
- “Багшийн хөгжил арга зүйн асуудал” эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж, төсөв, үйл явдлын зураг, тайлан
- Erasmus agrow төслийн холбогдох баримт бичиг, хамрагдсан багш нарын мэдээлэл, батламж
- Багшийн хөгжлийн төвөөс хэрэгжүүлсэн сургалтын үйл ажиллагааны баримтууд
- Багшийн арга зүйн туршлага солилцох үзүүлэх хичээлийн үйл явц

#### Шаардлага 5.1-ын нотлох баримт

- Тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгаа
- Ашиглагдаж буй программын танилцуулга
- Lib4U Номын сангийн цогц программын танилцуулга
- Өндөр хурдны интернэт үйлчилгээний талаар байгуулсан гэрээ
- Хяналтын камер суурилуулалт, дотоод сүлжээ зохион байгуулах байгууллагатай хийсэн гэрээ
- Тоног төхөөрөмж худалдан авсан нэгтгэл
- Сургалтын программын танилцуулга, ашиглах зааварчилгаа
- Тоног төхөөрөмж ашиглалтын карт

#### Шаардлага 5.2-ын нотлох баримт

- Номын сангийн тоног төхөөрөмжийн жагсаалт
- Номын сангийн танилцуулга
- СТЕППЕЛИНК ХХК-тай байгуулсан гэрээ, танилцуулга
- Цахим номын сангийн танилцуулга
- Цахим хэлбэрт шилжсэн бүтээл, фондын жагсаалт
- Мэргэжлийн ном сурах бичгийн жагсаалт /шинжлэх ухаан тус бүрээр/
- Боловсрол судлал /Сурган хүмүүжүүлэх зүй, боловсрол судлал, боловсролын менежментийн чиглэлийн номын фондын жагсаалт/
- Шинэ номын танилцуулгууд
- Номын сангийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан
- Номын санд авсан номын жагсаалт
- Гадаад хэвлэлийн жагсаалт
- ҮНС-тай байгуулсан ном солилцооны гэрээ
- Нээлттэй эх сурвалжуудын жагсаалт, түүний ашиглах зааварчилгаа



#### Шаардлага 5.3-ын нотлох баримт

- Бидсолюшн компанитай байгуулсан гэрээ
- Дээд боловсролын байгууллагын хөгжлийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр “ОТИС-ийн сургалтад багц цагийн системийг нэвтрүүлэх нь” төслийн тайлан
- OneMIS их дээд сургуулийн удирдлагын мэдээллийн системийн танилцуулга

#### Шаардлага 5.4-ын нотлох баримт

- Сургуулийн танилцуулга
- Докторантын гарын авлага /Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцагчийн үнэлгээний аргачлал бүгд багтсан/
- Хөтөлбөр тус бүрийн товч танилцуулга
- Цахим элсэлтийн <http://otgontenger.gate.mn/> программын танилцуулга

#### Шаардлага 5.5-ын нотлох баримт

- Тоног төхөөрөмж худалдан авсан нэгтгэл
- Сургалтын төлбөр тогтоосон УЗ-ын тогтоол
- Докторын сургалтын төлбөрийн хөнгөлөлтийн тушаал

#### Шаардлага 6.1-ын нотлох баримт

- Хөтөлбөрийн хорооны тушаал, хурлын тэмдэглэл
- ЗХШҮА-ны ажлын байрны тодорхойлолт, тушаал
- ОТИС-ийн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2019 он
- Докторантуудын сэтгэл ханамжийн судалгааны тайлан /2017, 2018, 2019/
- Багш нарын хөтөлбөр дэх оролцоо, хөтөлбөрийн шинэчлэлийн талаар авсан судалгааны тайлан /2019/
- Судалгааны мөрөөр хийх ажлын төлөвлөгөө 2017, 2018, 2019
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын сэтгэл ханамжийн судалгааны тайлан 2017, 2019
- Хяналт шинжилгээ, үнэлгээний гарын авлага 2015 он
- Чанарын гарын авлага 2018 он
- Үйл явцын зураглал 2018 он
- “Докторын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт” гарын авлага 2019 он
- Удирдагч багшийн үнэлгээний тайлан бичих загвар
- Докторантын судалгааны ажлын явцын тайлан бичих загвар

#### Шаардлага 6.2-ын нотлох баримт

- Магадлан итгэмжлэлийн гэрчилгээнүүд /хөтөлбөрийн болон байгууллагын/
- ISO гэрчилгээ
- ACBSP-ийн гэрчилгээ
- Аттестатчиллын гэрчилгээ

Хавсралт 2: Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн Магадлан  
итгэмжлэлийн шинжээчдийн Уулзалтад оролцогчид

**Удирдлага**

Уулзалт 2019 оны 05-р сарын 03-ны өдөр 303 тоотод

№	Овог нэр	Албан тушаал	Ажилласан жил	Холбоо барих дугаар
1.	Намсрайжав Энхзаяа	ОТИС-ийн захирал доктор	14	99992148
2.	Жаргалсайхан Золбаяр	ОТИС-ийн Бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал	3	99999029
3.	Батсайхан Одгэрэл	ОТИС-ийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал доктор, дэд профессор	13	99858426
4.	Энхбат Номин	ОТИС-ийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал доктор, дэд профессор	10	88096423
5.	Хуяг Энхтуяа	ОТИС-ийн ХС-ийн захирал доктор, дэд профессор	20	99097233
6.	Андрай Буянжаргал	ОТИС-ийн Захиргаа, хяналт шинжилгээ үнэлгээний албаны дарга	9	99055279
7.	Лувсандагва Мягманхүү	ОТИС-ийн сургалтын нэгдсэн албаны дарга	10	99882882

**Өөрийн үнэлгээний баг**

№	Овог нэр	Албан тушаал	Оролцоо	Холбоо барих дугаар
1	Батсайхан Одгэрэл	ОТИС-ийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал доктор, дэд проф	ӨҮТ-ийн ажлын хэсгийн ахлагч	99858426
2	Андрай Буянжаргал	ОТИС-ийн Захиргаа, хяналт шинжилгээ үнэлгээний албаны дарга	ӨҮТ-ийн ажлын хэсгийн нарийн бичиг	99055279
3	Лувсандагва Мягманхүү	ОТИС-ийн сургалтын нэгдсэн албаны дарга	гишүүн	99882882
4	Хуяг Энхтуяа	ОТИС-ийн ХС-ийн захирал доктор, дэд профессор	гишүүн	99097233
5	Батсайхан Энхбаяр	Сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлалын тэнхимийн эрхлэгч	Гишүүн	99961092
6	Сандуй Одхүү	Боловсрол судлалын багш	Гишүүн	99184136
8	Д.Эрдэнэчимэг	ХЗС-ийн захирал	Гишүүн	99901018
9	Н.Хосбаяр	АХТ-ийн эрхлэгч	Гишүүн	99700588

### Удирдагч багш нар

Уулзалт 2019 оны 05-р сарын 02-ны өдрийн 14:30-15:30 цагт 301 тоотод

№	Овог нэр	Зэрэг цол	Албан тушаал	Мэргэжлийн чиглэл
1.	Луухүү Жамц	Доктор (Sc.D) профессор	ОТИС-ийн зөвлөх профессор	Боловсрол судлал
2.	Лэгцэг Баасан	Доктор (Sc.D) профессор	ОТИС-ийн зөвлөх профессор	Эрх зүй
3.	Панз Цэрэндондов	Доктор (Ph.D) профессор	ОТИС-ийн зөвлөх профессор	Сэтгэл судлал
4.	О.Пүрэв	Доктор (Sc.D) профессор	Зочин профессор	Боловсрол судлал

### Багш нар

Уулзалт 2019 оны 05-р сарын 02-ны өдрийн 14:30-15:30 цагт 301 тоотод

№	Овог нэр	Зэрэг цол	Албан тушаал	Мэргэжлийн чиглэл
1.	Бүдрэгч Галиндэв	Доктор (Ph.D) профессор	ОТИС-ийн профессор	Боловсрол судлал
2.	Сандуйжав Одхүү	Доктор (Ph.D) профессор	ОТИС-ийн профессор	Боловсрол судлал
3.	Гаанжуурсүрэн Жаргалсайхан	Доктор (Ph.D) дэд профессор	ОТИС-ийн профессор	Хэл шинжлэл
4.	Маньбадар Сувд	Доктор (Ph.D) дэд профессор	ОТИС-ийн профессор	Эрх зүй
5.	Маньбадар Довууч	Доктор (Ph.D) дэд профессор	ОТИС-ийн профессор	Эдийн засаг
6.	Нанзаддорж Отгонбаяр	Доктор (Ph.D)	ОТИС-ийн ЭЗБУС-ийн захирал	Менежмент
7.	Ч.Лхагвасүрэн	Доктор (Ph.D)	Зочин профессор	Боловсрол судлал
8.	Дашпунцаг Эрдэнэчимэг	Докторант	ОТИС-ийн ХЗ сургуулийн захирал Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	Эрх зүй
9.	Ч.Соёлмаа	Доктор (Ph.D) дэд профессор	ОТИС-ийн багш	Хэл шинжлэл
10.	С.Алтантуяа	Доктор (Ph.D)	ОТИС-ийн багш	Хэл шинжлэл
11.	Д.Дарьмаа	Ахлах багш	ОТИС-ийн багш	Боловсрол судлал

### Ажил олгогчийн төлөөлөл

Уулзалт 2019 оны 05-р сарын 03-ны өдрийн 11.30-12.15 цагт 301 тоотод

№	Овог нэр	Зэрэг цол	Мэргэжлийн чиглэл	Эрхэлж буй ажил	Холбоо барих утас
5.	Г.Гантөмөр	Доктор (Ph.D) профессор	Хууль эрх зүй	ДХИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	99181473
6.	З.Болормаа	Дэд профессор	Багш	НБГ-ын СӨБ хариуцсан ахлах мэргэжилтэн	99990384
7.	М.Цогзолмаа		Багш	БЗД-ийн БХ-ийн дарга	99160546
8.	П.Лхагвасүрэн	Доктор (Ph.D) профессор	Багш	БХ-ийн захирал	99096868
9.	Б.Цэрэндаваа		Боловсрол судлал	Төв аймгийн засаг даргын ТГ-ын дарга	96068885

### Төгсөгчдийн төлөөлөл

Уулзалт 2019 оны 05-р сарын 03-ны өдрийн 10.15-11.00 цагт 301 тоотод

№	Овог нэр	Зэрэг цол	Мэргэжлийн чиглэл	Эрхэлж буй ажил	Холбоо барих утас
1.	Б.Жигжидсүрэн	Доктор (Ph.D)	Англи хэлний багш	ОУУБИС-ийн тэнхимийн эрхлэгч	99818100
2.	М.Ариунаа	Ахлах багш	Хууль, эрх зүй	ОТИС-ийн хууль зүйн клиник сургалтын төвийн эрхлэгч	99817012
3.	Б.Гэрэлцэцэг	Доктор (Ph.D) профессор	СӨБ-ын багш	115-р цэцэрлэгийн эрхлэгч	96667275